НИЙГМИЙН БОДЛОГЫН ХЭЛТСИЙН ДАРГА Ж.АМГАЛАНБААТАРЫН
2025 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ,
ҮР ДҮН, МЭРГЭШЛИЙН ТҮВШИНГ ҮНЭЛЭХ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС

Байгууллагын нэр: Нийгмийн бодлогын хэлтэс

**1. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээ | Гүйцэтгэлийн түвшин | Нийт (70 оноо) |
|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 |
| 1. | Нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт | Биелэлтийн хувь = (Нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийн хувь) | (Биелэлтийн хувь * 70 / 100%) |
| | Гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт | 98,1% | 68,7 |

**2. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Арга хэмжээний биелэлтийн хувь | Төсвийн шууд захирагчийн өгсөн үнэлгээ (15 хүртэл оноогоор) |
|---|---|---|---|
| 1. | Монгол бичгийн сурсан мэдсэнээ чадавхжуулж ахиц гаргана. | 100. | 15.0 |
| 2. | Богино хугацааны мэргэшүүлэх сургалтад хамрагдана. | 100 | 15.0 |
| 3. | Шинээр гарч буй болон нэмэлт өөрчлөлт орсон хууль тогтоомж даган гарсан журам, шийдвэрүүдийг судалж, албаны үйл ажиллагаанд ашиглаж нэвтрүүлнэ. | 96.6 | 14.5 |
| **Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний дундаж оноо** | | | 14.8 |

**3. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ**

| Д/д | Үзүүлэлт | Төсвийн шууд захирагчийн өгсөн үнэлгээ (15 хүртэл оноогоор) |
|---|---|---|
| 1. | Хандлага, ёс зүй | 15.0 |
| 2. | Удирдан зохион байгуулах | 14.5 |
| 3. | Асуудал шийдвэрлэх | 14.5 |
| 4. | Манлайлах | 15.0 |
| 5. | Багаар ажиллах | 15.0 |
| 6. | Харилцаа | 15.0 |
| Ур чадварын үзүүлэлт (ажлын онцлогоос хамаарсан) | | |
| 7. | Мэргэжлийн ур чадвар 1. | 15.0 |
| 8. | Мэргэжлийн ур чадвар 2. | – |
| 9. | Мэргэжлийн ур чадвар 3. | – |
| **Хандлага, ёс зүй, ур чадварын дундаж оноо** | | 14.8 |

4. **Гүйцэтгэлийн үнэлгээ**

| Д/д | Үнэлгээний үзүүлэлт | Үзүүлэлт тус бүрийн оноо |
|---|---|---|
| 1. | Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт<br>*(Нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт)* | 68.7 |
| 2. | Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт<br>*(Төсвийн шууд захирагчийн үнэлгээ )* | 14.8 |
| 3. | Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ<br>*(Төсвийн шууд захирагчийн үнэлгээ )* | 14.8 |
| 4. | Үнэлгээний оноонд орсон өөрчлөлт<br>*(Аргачлалын 6 дугаар хэсэгт заасан холбогдох заалтыг бичих)* | |
| **Нийт оноо =**<br>( Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний оноо + Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний оноо + Хандлага, ёс зүй, ур чадварын оноо ) - Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу хассан оноо | | 98.3 |

***Үнэлгээ өгсөн:*** ***Төсвийн шууд захирагч***

Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга .............................. /Ш.Эрдэнэбат/

2025.12.10
*(огноо)*

***Үнэлгээтэй танилцаж, зөвшөөрсөн:*** ***Нэгжийн дарга:***

Нийгмийн бодлогын хэлтсийн хэлтсийн дарга .............................. /Ж.Амгаланбаатар/

2025/12/09
*(огноо)*

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН НИЙГМИЙН БОДЛОГЫН ХЭЛТСИЙН
2025 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАНГИЙН ТОВЧОО

2025.12.04 Алтай хот

| | | |
|---|---|---|
| Хяналтад авсан арга хэмжээний тоо | | 49 |
| Үнэлгээ | Арга хэмжээний хүрэх түвшинд бүрэн хүрсэн /100%/ | 42 |
| | Арга хэмжээний хүрэх түвшинд бүрэн хүрээгүй боловч зохион байгуулалтын арга хэмжээ бүрэн авагдсан/90%/ | 6 |
| | Өөрсдөөс хамаарах шийдвэрийг гаргасан, санхүүгийн асуудал шийдвэрлэгдсэн, гүйцэтгэл тодорхой хэмжээгээр гарч эхэлж байгаа/70%/ | 1 |
| | Тухайн зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх бэлтгэл болон боловсруулалтын шатны ажил бүрэн хийгдсэн, ажил тодорхой хэмжээнд эхэлсэн/50%/ | |
| | Тухайн зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх бэлтгэл ажил хийгдэж дуусаад боловсруулалтын шатанд байгаа/30%/ | |
| | Хэрэгжээгүй /0/ | |
| БИЕЛЭЛТИЙН ДУНДАЖ ХУВЬ | | 98,1 |

# АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН НИЙГМИЙН БОДЛОГЫН ХЭЛТСИЙН 2025 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

2025.12.04 Алтай хот

| № | Хэрэгжүүлэх арга хэмжээ | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хэрэгжилт | Хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| **НЭГ.Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт, арга хэмжээ** | | | | | | | |
| **1.1 Эрүүл мэндийн чиглэлээр** | | | | | | | |
| 1.1.1 | Халдварт бус өвчний эрт илрүүлгийн хамрагдалтын хувийг нэмэгдүүлж, илэрсэн өвчлөлийг хяналтад авч эмчлэн эрүүлжүүлнэ. | УТ, ОНТ | Артерийн даралт ихсэх өвчний эрт илрүүлэг үзлэгийн хувь | 61.2 | 82 | Эхний 11 сарын байдлаар артерийн гипертензийн эрт илрүүлэгт хамрагдвал зохих 34286 хүний 59.8%-ийг хамруулсан нь өмнө оны (63.7) мөн үетэй харьцуулахад 3.9%-иар буурсан үзүүлэлттэй байна. Шинээр оношлогдсон 217 хүнийг эмчилгээнд хамруулан хяналтад авлаа. | 70 |
| | | | Чихрийн шижин өвчний эрт илрүүлэг үзлэгийн хувь | 69.7 | 71.6 | | |
| 1.1.2 | “Говь-Алтай 80+” эрүүл мэндийн хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж ажиллана. | ОНТ | Хөтөлбөрийн төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | 80% | 90-ээс доошгүй хувь | Эхний 11 сарын байдлаар чихрийн шижин өвчний эрт илрүүлэгт хамрагдвал зохих 22846 хүний 70.3% нь хамрагдаж өмнө оны (74) мөн үетэй харьцуулахад 3.6%-иар буурсан үзүүлэлттэй байна. Шинээр оношлогдсон 53 хүнийг эмчийн хяналтад авч эмчилгээнд хамрууллаа | 100 |
| 1.1.3 | Хөнгөлөлттэй нөхцөлөөр олгох орон сууцанд хамрагдах хөтөлбөрт эрүүл мэндийн ажилтныг хамруулна. | ОНТ | Дэмжлэг үзүүлсэн эрүүл мэндийн ажилтны тоо | 80 | 80 | Аймгийн хөгжлийн 2025 оны төлөвлөгөөнд эрүүл мэндийн ажилтныг “Түрээсийн орон сууц”-ны хөтөлбөрт хамруулахад дэмжлэг үзүүлэхэд 880,0 сая төгрөгийг батлуулж, 2025 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр 80 эрүүл мэндийн ажилтанд тус бүр 10,0 сая төгрөгийг олголоо. | 100 |
| 1.1.4 | НЭҮНШТ-ийн чиглэлээр эмнэлгийн мэргэжилтнийг чадавхжуулах сургалтыг зохион байгуулна. | УТ, ОНТ | Хамрагдсан эмнэлгийн мэргэжилтний тоо | 2 | 20 | НЭҮНШТ-ийн чиглэлээр сургагч багш эх баригч Цэрэндолгор, Мөнхтуяа, Бадамсүрэн нар Нэгдсэн эмнэлFгийн төрөх тасгийн 30 эх баригч, нярайн сувилагчдад ажлын байрны сургалтын 2 удаа зохион байгууллаа. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1.1.5 | Эрүүл мэндийн газар, Баянтоорой, Тонхил, Гуулин, Шарга, Төгрөг, Дэлгэр, Алтай 3 өрхийн Эрүүл мэндийн төв, Нэгдсэн эмнэлэг, уламжлат анагаах ухааны нэгдсэн эмнэлэгт автомашины парк шинэчлэлтийг ээлж дараатайгаар шинэчилнэ. | УТ, ОНТ | Парк шинэчлэгдсэн автомашины тоо | 11 | 3 | Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр Эрүүл мэндийн яамны хэрэгжүүлж буй "Цар тахлын эсрэг шуурхай арга хэмжээ авах эрүүл мэндийн тогтолцооны чадавхыг бэхжүүлэх" МОН-9218 төсөл, Эрүүл мэндийн сайдын 2025 оны А/93 дугаар тушаалаар нийлүүлэгдсэн 3,1 тэрбум төгрөгийн үнэ бүхий иж бүрэн тоноглогдсон явуулын 2 автомашиныг Нэгдсэн эмнэлэгт нийлүүллээ. Дэлхийн банкны санхүүжилтээр Гуулин тосгон, Шарга сумын Эрүүл мэндийн төвд 417,3 сая төгрөгийн LandCruiserJ78 маркийн түргэн тусламжийн автомашиныг олголоо. | 100 |
| 1.1.6 | Багийн эмчийн унааг ээлж дараатайгаар шинэчилнэ. | УТ, ОНТ | Хангагдсан багийн эмчийн тоо | - | 16 | Аймгийн засаг дарга Г.Чинбатын санаачлагаар "Говь-Алтай 80+" эрүүл мэндийн хөтөлбөрийн хүрээнд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг анхан шатанд хамгийн түрүүнд хүргэдэг багийн эмч нарыг PROBOX автомашинаар унаажуулах ажлын хүрээнд 2025 онд Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн 200 сая төгрөгийн санхүүжилтээр Хөхморьт сумын Сангийн далай, Хүйсийн говь баг, Баян-Уул сумын Алтангадас баг, Баян-Уул сумын Баянговь баг, Тонхил сумын Алтансоёмбо баг, Дарви сумын Хужирт баг, Дэлгэр сумын Баянхонгор багийн эмч нарт. Нийгмийн хариуцлагын хүрээнд гэрээ байгуулан Хан-Алтай ресурс ХХК, Цэн Газар ХХК-аас Тонхил сумын Зүйл, Бүс баг, Цогт сумын Баян-Өндөр, Далан, Рашаант, Гэгээт баг, Баян-Уул сумын Чандмань хайрхан, Баян хайрхан баг, Шарга сумын Сондуулт, Хамтын хүч, Улаан туг баг, Тайшир сумын Хуримт, Далан, Галуут баг, Дэлгэр сумын Баян-Өндөр баг, Алтай сумын Баянцагаан баг, Халиун сумын Чацран баг, Эрдэнэ сумын Сангийн далай баг, Цээл сумын Дэрстэй баг, Төгрөг сумын Төгрөгийн эх баг, Бигэр сумын Мянгай, Хүрэмт, Их булаг баг, Есөнбулаг сумын Наран баг, Жаргалан сумын Завхан гол баг, Дарви сумын Жавхлант баг, Бугат сумын Ферм, Сүж баг, Чандмань сумын Өлзийбулаг, Эрдэнэ-Уул баг нийт 950 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 18 сумын 38 багийн эмч нар Probox автомашинаар хангагдлаа. Өмнө онд 8 машин | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | нийлүүлэгдсэн бөгөөд нийт 46 багийн эмчийг автомашинаар хангаад байна | |
| 1.1.7 | Эрүүл мэндийн байгууллагын оношилгоо эмчилгээний тоног төхөөрөмжийн хангалтыг нэмэгдүүлнэ. | УТ, ОНТ | Эрүүл мэндийн байгууллагын оношилгоо эмчилгээний тоног төхөөрөмжийн тоо | 12 | 6 эрүүл мэндийн байгууллага | Америкийн Нэгдсэн Улсын Засгийн газрын буцалтгүй тусламжийн хүрээнд Эрүүл мэндийн сайдын 2025 оны А/09 дүгээр тушаалаар ЭМГ-т хуваарилсан 2,7 сая төгрөгийн үнэ бүхий 54 ширхэг пульсоксиметрийг 19 эрүүл мэндийн байгууллагад, Бүгд найрамдах Австрали улсын Засгийн газрын хөнгөлттэй зээлийн санхүүжилтээр "Хавдрын урьдчилан сэргийлэлт, эрт илрүүлгийн үндэсний сүлжээ байгуулах" төслийн хүрээнд Эрүүл мэндийн сайдын 2025 оны А/167 дугаар тушаалаар Нэгдсэн эмнэлэгт 50,1 сая төгрөгийн ходоодны дуран, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар эрүүл мэндийн сайдын тушаалаар Алтай, Жаргалан сумын эрүүл мэндийн төвд 54,7 сая төгрөгийн зөөврийн ЭХО аппарат, Эрүүл мэндийн сайдын 2025 оны А/171 дүгээр тушаалаар Зоонозын өвчин судлалын төвд 5,5 сая төгрөгийн 2 нэр төрлийн 2 ширхэг лабораторийн хөргөгч, Монгол улсын 2025 оны төсвийн тухай хуулийн хүрээнд Ерөнхийлөгчийн санаачилгаар хэрэгжиж буй "Эрүүл монгол хүн" хөтөлбөрийн хүрээнд 76,9 сая төгрөгийн Зүрхний цахилгаан бичлэгийн аппарат 17 сум 2 тосгон 3 өрхийн эрүүл мэндийн төвд, Люксембургийн Их Гүнт улсын буцалтгүй тусламжаар "Монгол улс дахь зүрх судлал, зүрхний мэс засал ба телемедицин" МОН/007 төслийн хүрээнд Нэгдсэн эмнэлэгт нийт 22,6 сая төгрөгийн 5 нэр төрлийн 10 ширхэг тоног төхөөрөмж нийлүүлэгдэж, нийт 24 эрүүл мэндийн байгууллагад 9 нэр төрлийн 91 ширхэг 212,5 сая төгрөгийн тоног төхөөрөмж нийлүүлэгдлээ. Олон улсын Ротари Сангийн дэмжлэгтэйгээр АНУ-ын PROJECT C.U.R.E байгууллага, Улаанбаатар Ротари Клуб, Хүннү Ротари Клуб, АНУ дахь Дэнвер Ротари Клуб, Францын Парис Ротари Клубтай хамтран GG2454132 төсийн хүрээнд аймгийн Нэгдсэн эмнэлэг, Алтай, Дэлгэр, Шарга, Цогт, Бугат, Тайшир сумын эрүүл мэндийн төвүүдэд нийт 200 гаруй нэр төрлийн 206.000 ширхэг 400,000 доллар буюу 1.2 тэрбум төгрөг эмнэлгийн тоног төхөөрөмж болон эмнэлгийн хэрэгслийг хандивлалаа. | 100 |
| 1.1.8 | "Эрүүл шүд-эрүүл хүүхэд" арга хэмжээний | УТ, ОНТ | Арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | 92.2% | Суурь түвшингээс доошгүй | Тус арга хэмжээний төлөвлөгөөг 6 зорилтын 22 үйл ажиллагаа төлөвлөж хэрэгжилт 93.5%. Хүн амын дунд амны хөндийн эрүүл мэндийн эрсдэлт хүчин зүйлсийг | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хэрэгжилтийг хангаж ажиллана. | | | | | бууруулах, эрүүл мэндийн боловсрол олгох, иргэн бүрт зөв дадлыг хэвшүүлэх "24/3 ШҮДЭЭ ЗӨВ УГАА-2025" аяныг 19 эрүүл мэндийн байгууллага зохион байгуулж амны хөндийн эрүүл мэндийн боловсрол олгох сургалтад хүүхэд 2776, насанд хүрэгч 2322 нийт 5098 хүн хамрагдлаа. Ерөнхий боловсролын 7 сургууль шинээр шүд угаах цэг байгуулж, сурагчдын үдийн хоолны дараа "Шүд угаах" цагийг 15 сумын 91 бага анги хэвшүүлж 4471 хүүхэд шүдээ сургууль дээр угаах боломж бүрдлээ. Мөн 15 сумын сургуулийн өмнөх байгууллагын 105 бүлэг шүд угаах булан байгуулснаас 71 бүлгийн 1747 хүүхэд шүдээ тогтмол угаадаг болсон байна. ЭМЯ, НЭМҮТ-ээс боловсруулсан 6 төрлийн инфографыг цахимд байршуулан 94 байгууллага нэгдэж 788 шэйр хийж 11197 хандалт авлаа. Явуулын эмнэлэг Хөхморьт, Баян-Уул суманд ажиллаж насанд хүргэгч 54, хүүхэд 36 нийт 90 хүнд шүдний тусламж үйлчилгээ үзүүллээ. Сургуульд суурилсан эрт илрүүлгийн үзлэгээр аймгийн хэмжээний 1 дүгээр ангийн хүүхдээс шүдний үзлэгт хамрагдвал зохих 1143 хүүхдийн 1112 буюу 97.3% -ийг хамрууллаа. Үүнээс 642 буюу 57.7 нь шүдний цооролтой байсныг 100 хувь эмчилгээнд хамрууллаа. Энэ онд 11 сумын эрүүл мэндийн төвд 2-12 насны, аймгийн төвийн 3 сургуулийн 6-12 насны хүүхдийн дундах шүдний өвчлөлийн судалгаа хийхэд шүдний цоорлын хувь 78.4% байна.Энэ онд НҮБ-ын Хүүхдийн сангаас Шарга, Тонхил, Хөхморьт сумын эрүүл мэндийн төв шинээр шүдний тоног төхөөрөмж нийлүүлснээр аймгийн 19 сумаас 11 буюу 57.9 нь шүдний тоног төхөөрөмжөөр хангагдлаа. | |
| 1.1.9 | "Иргэний эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх" арга хэмжээний хэрэгжилтийг хангаж ажиллана. | УТ, ОНТ | Арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | 88.7% | 90%-иас доошгүй | Иргэний эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх чиглэлээр Эрүүл мэндийн газрын даргын 2025 оны А/06 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар эрүүл мэндийг дэмжих өдрүүдийг тэмдэглэх хуваарийг, 2 дугаар хавсралтаар сургалт, сурталчилгааны 23 заалт бүхий төлөвлөгөө батлан харьяа 24 байгууллагад хүргүүлснээр нэгж байгууллагуудаас сар бүр эрүүл мэндийн боловсрол олгосон сэдэв, хамрагдсан иргэдийг тоог авч нэгтгэж байгаа бөгөөд аймгийн хэмжээнд сургалтад 50720 хүн, сурталчилгаанд 52393, нөлөөллийн ажилд 4154 хүнийг хамрагдсан байна. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | “Говь-Алтай аймгийн эрүүл мэндийн газар” цахим хуудсанд цаг үеийн болон эрүүл мэндийн 607 төрлийн мэдээлэл оруулж давхардсан тоогоор 1607523 хүнд , харьяа эрүүл мэндийн байгууллагууд 197 цахим хуудсанд 461 мэдээлэл байршуулан 15565 хандалт авлаа. Иргэдийн эрүүл мэндийн боловсролыг нэмэгдүүлэх үйл ажиллагааны үр дүнд энэ онд эрүүл мэндийг дэмжигч байгууллага 3-аар нэмэгдэж, 15 хүн тамхинаас татгалзан, 14 хүн архинаас гарсан байна.арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт 88.5% байна | |
| 1.1.10 | Аймгийн авто замын осол ихээр гардаг Хар цэг, түүнтэй ойр байрлах Дэлгэр, Шарга сумын эрүүл мэндийн төвийг ослын үеийн яаралтай түргэн тусламж үзүүлэх нэгжийн нөхцөл боломжоор хангахад хяналт тавих, яаралтай түргэн тусламж үзүүлэх үйл ажиллагааны тасралтгүй байдал, нөөц бүрдүүлэлтийг хангахад дэмжлэг үзүүлж ажиллана. | УТ, ОНТ | Эмнэлгийн яаралтай тусламжийн нэгж байгуулсан тоо | - | 1 | Дэлгэр сумын эрүүл мэндийн төвд нэгжийг байгуулж, тусламж үйлчилгээ үзүүлэх 3 багийг томилон тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг хангаан ажиллаж байна. Цаашид ослын үеийн яаралтай тусламж үзүүлэх багцууд шаардлагатай байна. | 90 |
| **1.2. Биеийн тамир, спортын чиглэлээр** | | | | | | | |
| 1.2.1 | Хүн амын бие бялдарын түвшин тогтоох сорилыг жилд 2 удаа зохион байгуулна. | УТ, ОНТ | Сорилд хамрагдсан нийт иргэдийн тоо, ABC үнэлгээтэй иргэдийн тоо | 2024 онд нийт хүн амын 6 хувийг хамруулсан | Нийт хүн амын 7 хувийг хамруулсан байна | “Говь-Алтай 80+” хөтөлбөр, “Эрүүл Монгол хүн” үндэсний хөдөлгөөний хүрээнд Монгол улсын Ерөнхийлөгчийн 2010 оны 53-р тоот зарлиг “Хүн амын бие бялдрын хөгжил чийрэгжүүлэлтийн түвшин тогтоох сорил”-д аймгийн 18 сум Алтай хотын сургуулийн өмнөх боловсролын байгууллагын албан хаагчдаас сорил авч авч 3484 иргэн хамрагдсанаас 1681 хүн буюу сорилд хамрагдсан нийт иргэдийн 48,2 хувь ABC үнэлэгдлээ. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | А үнэлгээтэй – 12.9 хувь<br>В үнэлгээтэй – 20.3 хувь<br>С үнэлгээтэй – 17.8 хувьтай байна. Уг ажлыг эрчимжүүлэх үүднээс "Хүн амын бие бялдар чийрэгжүүлэлтийн түвшин тогтоох сорил"-ын аяныг эхлүүллээ. 2025 оны 05 дугаар сарын 02-ны өдөр сумдын нийгмийн ажилтан, биеийн тамирын орон тооны арга зүйч нарт "Дасгал хөдөлгөөн хийхийн ач тус" болон "Сорил авах арга аргачлал" сэдвээр сургалт зохион байгууллаа. Сорил авах захирамжийн ажлын хүрээнд бүх сумдын нийгмийн ажилтан, биеийн тамирын арга зүйч нарын дунд "Сорил авах арга зүйч" "Дасгал хөдөлгөөн хийхийн ач тус" сэдвээр онол практик хосолсон сургалтыг зохион байгуулж 18 сумын 300 хүн хамрагдлаа. Сумдын нийт хүн амын 20 хувь, төрийн албан хаагчдаас сорил авч хагас жилээр нийт 4431 иргэнээс сорил авч ажиллаа. | |
| 1.2.2 | Говь-Алтай 80+ хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд нийтийн биеийн тамирыг эрүүл идэвхтэй амьдралын хэв маяг болгон, биеийн тамираар хичээллэх иргэдийн тоог нэмэгдүүлнэ. | УТ, ОНТ | Зохион байгуулсан тэмцээн уралдааны тоо, хамрагдсан иргэдийн тоо | 2024 онд 7962 иргэн хамруулсан | Нийтийн биеийн тамирын 19 ажлыг зохион байгуулж 8000 иргэн хамруулсан байна. | "Эрүүл Монгол хүн" үндэсний хөдөлгөөн, "Говь-Алтай 80+" хөтөлбөрийн хүрээнд өглөө бүр 06:30-08:30 цагт иргэдэд спорт заалыг үнэ төлбөргүй ашиглуулж, давхардсан тоогоор 14,261 иргэн өглөөний дасгалд, долоо хоног бүрийн Даваа, Лхагва гаригт 11:00-14:00 цагийн хооронд ахмадуудад заалыг үнэ төлбөргүй ашиглуулж, давхардсан тоогоор 2840 ахмад хамрагдлаа. Төрийн болон төрийн бус 20 байгууллагын 2400 /давхардсан тоогоор/ гаруй албан хаагч 7 хоног бүр 18:00-22:00 цагуудад биеийн дасгал хөдөлгөөн хийж байна. Биеийн тамир спортын газар нь 2025 онд нийтийн биеийн тамирын 20 ажил төлөвлөж зохион байгуулж / Өвлийн спортын арга хэмжээ-1,волейбол-3, сагсан бөмбөг-2, үндэсний бөх-3, бүх нийтийг хамарсан арга хэмжээ-3, хүүхдэд чиглэсэн арга хэмжээ-3 / зохион байгуулан хэрэгжүүлж 1,875 хүн хамрагдлаа. Монголын эмэгтэйчүүдийн холбооны Говь-Алтай аймаг дахь салбар зөвлөл, Шугаман бүжгийн холбоотой хамтран шугаман бүжгийн сургалт, багш бэлтгэх сургалт өглөөний дасгал хөдөлгөөнийг зохион байгуулж 349 хүн хамрагдлаа. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Дээрх арга хэмжээнүүдэд аймгийн хэмжээнд нийт 21,476 иргэн хамрагдлаа. | |
| 1.2.3 | Аймгийн засаг даргын дэргэдэх өсвөрийн шигшээ багуудыг дэмжин “Аваргыг аймагтаа” арга хэмжээг үргэлжлүүлэн хэрэгжүүлж, тамирчдын залгамж халааг бэлтгэх, үр чадвар амжилтыг ахиулж улс, бүсийн тэмцээнд бэлтгэн оролцуулна. | УТ, ОНТ | Зохион байгуулсан тэмцээн уралдааны тоо, хамрагдсан тамирчдын тоо, гаргасан амжилт медалын тоо | Спортын 16 төрлөөр зохион байгуулж 1670 тамирчин хамрагдсан, бүс улсын аварга шалгаруулах тэмцээнээс 128 медаль хүртсэн | Спортын 16 төрлөөр зохион байгуулж 1800 тамирчин хамруулсан байна. Медалын тоог нэмэгдүүлсэн байна. | Аймгийн засаг даргын дэргэдэх өсвөр үеийн шигшээ багийг дэмжих “Аваргыг аймагтаа” арга хэмжээг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх ажлын хүрээнд аймгийн засаг даргын дэргэдэх өсвөр үеийн шигшээ багийг спортын 10 төрлөөр /волейбол, сагсан бөмбөг, жүдо, чөлөөт бөх, шатар, хөл бөмбөг, хөнгөн атлетик, таеквондо, самбо/ нийт 292 гаруй өсвөр үеийн тамирчид бэлтгэгдэж байна. Монголын хүүхдийн спортын VIII их наадмын анхан шат өсвөр үеийн аймгийн аварга шалгаруулах тэмцээн спортын 12 төрлөөр / волейбол, сагсан бөмбөг, сагсан бөмбөг 3х3, хөл бөмбөг, жүдо, чөлөөт бөх, самбо, ширээний теннис, таеквондо, хөнгөн атлетик, шатар, даам, мини волейбол / зохион байгууллаа. Өсвөр үеийн аймгийн аварга шалгаруулах тэмцээнд 18 сум Алтай хотын 5 сургуулийн нийт 2261 хүүхэд хамрагдлаа. Шинэ тутамд хөгжиж буй спортын төрлийг аймагтай түгээн дэлгэрүүлэх хөгжүүлэхээр аэробик гимнастикийн анхан шатны сургалтыг зохион байгуулж явууллаа. 2025 оны 05 дугаар сарын 26-аас 06 дугаар сарын 06-ны өдрүүдэд Улаанбаатар хотод зохион байгуулагдсан “Мөрөөдлийнхөө төлөө шударгаар өрсөлдье” уриатай Монголын хүүхдийн спортын зуны VIII их наадмын Аэробик гимнастикийн эмэгтэй төрөл болон багийн төрөл алт, эрэгтэй төрөлд мөнгө медаль хүртлээ. | 100 |
| 1.2.4 | Монголын хүүхдийн спортын их наадмыг аймаг орон нутагтаа 2 үе шаттай зохион байгуулж бүс, улсын аварга шалгаруулах тэмцээнд тамирчдыг бэлтгэн оролцуулах, өмнөх амжилтыг ахиулна. | УТ, ОНТ | Зохион байгуулсан тэмцээн уралдааны тоо, гаргасан амжилт медалын тоо. | Спортын 15 төрлөөр зохион байгуулж 1809 тамирчин хамрагдсан, шигшээ тэмцээнд спортын 12 төрөлд | 16 төрлөөр зохион байгуулж 2100 тамирчин хамруулсан байна. Шигшээ тэмцээнд 12 төрөлд 200 тамирчин оролцуулсан байна. | Аймгийн Засаг даргын дэргэдэх өсвөр үеийн шигшээ багийг спортын 10 төрлөөр зохион байгуулж, 292 тамирчин бэлтгэгдэж байна. Монголын хүүхдийн спортын VIII их наадмын анхан шат өсвөр үеийн аймгийн аварга шалгаруулах тэмцээн спортын 16 төрлөөр / волейбол, сагсан бөмбөг, сагсан бөмбөг 3х3, хөл бөмбөг, жүдо, чөлөөт бөх, самбо, ширээний теннис, таеквондо, хөнгөн атлетик, шатар, даам, мини волейбол / зохион байгуулж, 18 сумын нийт 2850 хүүхэд хамрагдлаа.<br><br>Монголын бүх ард түмний спортын XVI их наадмын аймгийн аварга шалгаруулах насанд хүрэгчдийн | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | 134 тамирчин хамрагдсан | | тэмцээнийг спортын 10 төрлөөр/волейбол, сагсан бөмбөг, ширээний теннис, шатар, даам, самбо, чөлөөт бөх, пауэрлифтинг/ зохион байгуулж 910 хүн хамрагдлаа.<br><br>Дээрх арга хэмжээнд нийт 4052 хүн хамрагдсан байна. | |
| **1.3. Боловсрол, шинжлэх ухааны чиглэлээр** | | | | | | | |
| 1.3.1 | "Боловсролын чанарыг сайжруулах хөтөлбөр"-ийг хэрэгжүүлнэ. | ОНТ | Арга хэмжээний тоо | 2 | 3 | Боловсролын газрын ажлын хэсэг 2025 оны 1 дүгээр сараас эхлэн салбарын багш, ажилтан, ажилчид, иргэдийн дунд хэлэлцүүлгийг хийж, засан сайжруулж хөтөлбөрийг шинэчлэн боловсруулсан. Хөтөлбөрийн танилцуулга, төслийг Засаг даргын зөвлөлийн хурал, намын бүлгүүд, ИТХ-ын төлөөлөгчид, ажлын алба зэрэг 5 удаагийн хуралд танилцуулан хэлэлцүүлж өөрчлөлт оруулан Говь-Алтай аймгийн ИТХ-ын 2025 оны 03 дугаар сарын 31-ний 06 дугаар тогтоолоор батлуулан хэрэгжүүлж ажиллаж байна. Хөтөлбөрийн хүрээнд урамшуулал олгох журмыг мөн хамтад нь /07 дугаар тогтоолоор/ баталсан. Энэ хүрээнд аймгийн төсөвт 2 тэрбум төгрөгийн төсвийг ИТХ-аас баталж зарцуулан ажиллаж байгаа ба 2025 онд амжилт гаргасан 173 багш, 155 сурагчдад нийт 5 арга хэмжээнд 621.5 сая төгрөгийн урамшуулал олгосон. Хөтөлбөр нь 2025-2028 оны хугацаанд хэрэгжих бөгөөд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг гарган хагас жил, жилээр биелэлт үр дүнг тооцон ажиллаж байна. Аймгийн Засаг дарга, НБХ-ээс өгсөн үүрэг чиглэлийн дагуу тус хөтөлбөрийг дахин засан сайжруулах, нэмэлт өөрчлөлт оруулах санал, хөтөлбөр урамшууллын талаарх сэтгэл ханамжийн цахим судалгааг нийт 20 сургууль, цэцэрлэгээс албан бичгээр, 3893 ажилтан албан хаагч, иргэдээс цахим санал асуулгаар авч нэгтгэж ажиллалаа. 2025 онд орон нутгийн төсвөөс тус хөтөлбөрийн хүрээнд нийт 816,3 сая төгрөгийг боловсролын салбарт зарцуулсан байна. | 100 |
| 1.3.2 | ЭЕШ-д бэлтгэл ажлын хүрээнд нэгдсэн болон судлагдахуун бүрээр олимпиад, сорилго шалгалтыг зохион байгуулж, ментор багш | ОНТ | Гүйцэтгэлийн дундаж | 486.8 | 501 | ЭШ-ын чанарт ахиц гаргах зорилготой "Алтайн ЭШ-2025" 5 сарын аяныг зохион байгуулж 12 чиглэлийн ажил төлөвлөн 100% хэрэгжүүллээ. ЭШ өгөх 12 дугаар ангийн сурагчид, тэдний эцэг эхчүүд, хичээл заагч болон АУБ нарт "МЭРГЭЖИЛТЭН ЗӨВЛӨЖ БАЙНА" онлайн эвент, "Мэргэжил бүхэн сайхан" ажлын байрны танилцах аялалд аймгийн 12-р ангийн 584 хүүхэд 21 байгууллага дээр очиж ажил мэргэжлийн онцлоготой | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | нарын баг ажиллуулан давтлага өгч ЭЕШ-ын дундаж оноог нэмэгдүүлнэ. | | | | | танилцлаа. ЭШ-ын 10 хичээл заагч багш нараас "ЧАНАРЫН ҮНЭЛГЭЭНИЙ СУДАЛГАА" авлаа. Шалгалтад нийт 407 багш хамрагдсан бөгөөд үнэлгээний дундаж 62.06 байлаа. Сар бүр 1 сорилго авахаар төлөвлөж Мексим консалтинг ХХК-тай хамтран 2 удаагийн нийт 20 шалгалтыг цахим сорилгыг зохион байгуулсан бөгөөд нийт 1346 суралцагч давхардсан тоогоор 4994 шалгалтыг өгсөн байна. Мөн Их Нүүдэл системтэй хамтран 10 судлагдахуунаар 2 удаагийн буюу нийт 20 төрлийн давхардсан тоогоор 6144 шалгалтыг зохион байгууллаа. Шалгалтын үр дүнд үндэслэн судлагдахуун бүрийн эхний 10, судлагдахуун бүрийн 50,50 сурагчийг сонгон "Урамшууллын давтлага"-д хамруулж 9 судлагдахуунаар 900 цагийн давлагад давхардсан тоогоор 10261 сурагчийг хамруулсан. Ментор багш нарын танхимын сургалтад 9 судлагдахууны 30 багш нийт 420 цагийн давтлагыг 4040 сурагчид өгсөн. 15000 сурагчийг хамруулсан "Алтайн ЭШ" их сорилго зохион байгуулж даалгаврын гүйцэтгэл, сургууль, анги, сурагчийн эрэмбийг гаргаж дүгнэлт хийсэн. 7 хоногийн хугацаатай 238 цагийн вакум давтлагыг Их нүүдэл системийн ментор багш нараар удирдуулан зохион байгуулж давхардсан тоогоор 6391 сурагч хамрагдаж байна. ЭШ-д амжилт үзүүлсэн багш, сурагч, сургууль, ахлах арга зүйчдийг урамшуулах "БЧС хөтөлбөрийн шагналын журам" боловсруулан батлуулсан. 8 сумд ЭШ-н чиглэлээр зөвлөн тусалж давхардсан тоогоор 510 шалгалт авч анхаарах агуулгыг судлагдахуун бүрээр гаргаж хугацаатай даалгавар өгч ажиллалаа. ЭШ-ын сорилгод цахимаар 11138, цаасан суурьтай сорилгод 1604 сурагч хамруулж, цахим болон танхимын 1558 цагийн давтлагад давхардсан тоогоор 20692 сурагч хамруулллаа.2025 оны элсэлтийн шалгалтад давхардсан тоогоор 2141 шалгуулагч 10 судлагдахуунаар хамрагдлаа. Нийт судлагдахууны дундаж 510,1%-тай шалгагдсан. Боловсролын чанарыг сайжруулах хөтөлбөрийн хүрээнд 600+ оноо авсан 90 сурагч, тэдгээрийг бэлтгэсэн 34 багш, улсын дунджаас дээгүүр үнэлэгдсэн 14 сургуулийг нийт 316 сая төгрөгөөр шагнаж урамшуулав.<br>Үр дүн: ЭШ-ын сорилгод цахимаар 11138, цаасан суурьтай сорилгод 1604 сурагч хамруулж, цахим болон | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | танхимын 1558 цагийн давтлагад давхардсан тоогоор 20692 сурагч хамрууллаа. Нийт судлагдахууны дундаж оноо 510.1, өмнөх оноос 2 байраар урагшилж 9-р байр эзэлсэн. | |
| 1.3.3 | Аймгийн хэмжээнд үндэсний хэл, бичиг үсгээ сурч судлах, эзэмших, хэрэглээг нэмэгдүүлэх, хамгаалах хөгжүүлэх, сурталчлах, түгээн дэлгэрүүлэх ажлыг зохион байгуулна. | ОНТ | Үйл ажиллагааны тоо | 1 | 1 | Аймгийн хэлний бодлогын салбар зөвлөлийн үйл ажиллагааны төлөвлөгөөг 3 зорилтын хүрээнд 25 арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлж байна. Байгууллагын албан хаагчдын монгол бичгийн чадварыг сайжруулахаар "Төрийн албан хаагчдын монгол бичгийн гарын авлага" номыг албан хаагч бүрт өгч ажиллуулсан. "Би монгол хүн" хөтөлбөр хэрэгжүүлэн, ухаан далай номоос эхтэй арга хэмжээ төлөвлөн бүх сургууль цэцэрлэгт хэрэгжиж байна. Байгууллагын албан хэрэг кирилл болон монгол бичгээр хослуулан хөтөлдөг. Байгууллагын дотор хаягийг монгол бичгээр бичсэн. Монгол бичгийн улсын 19-р уралдааныг 6,7,8,9,12 дугаар анги хамт олны хичээгүй бичиг, хэрэглээний чадвар, 10,11 дүгээр анги хамт олны зөв шударга уншлага, Дунд, ахлах ангийн ганцаарчилсан зөв шударга уншлага, 12 дугаар ангийн сурагч, Мэргэжлийн багш төрлүүдээр 2025 оны 03 дугаар сарын 10, 13,14, 22,23-ны өдрүүдэд зохион байгууллаа. Монгол бичгийн улсын XIX олимпиадын II даваанд нийт 2653 сурагч, 19 багш хамрагдаж 3-р шатнаас 1 анги хүрэл медаль, 1 сурагч тэргүүний уншигч, 1 багш 3-р байр, 1 сурагч тэргүүн байр, 1 багш тусгай байрын шагнал хүртлээ. П.Цэрэндорж агсны нэрэмжит монгол хэл бичгийн олимпиадыг мэргэжлийн багш, 12-р ангийн сурагч төрлөөр зохион байгуулсан. Тус олимпиадад 17 багш 20 сурагч оролцлоо. 2025.03.25-ны өдөр тус олимпиадын хүрээнд зохион байгуулагдсан мэргэжлийн багш нарт арга зүй, ур чадвар олгох сургалтыг монгол улсын зөвлөх багш Б.Цасанчимэг удирдан чиглүүлсэн. Сургалтад 30 багш хамрагдсан. Монгол хэлний багш нарыг мэргэжил арга зүйгээр хангаж 8 удаагийн цахим уулзалт сургалт зохион байгуулж, цахим хэрэглэгдэхүүн, сорил даалгаврын 1 бүлгэм ажиллуулж тогтмол шинэчлэн ажиллаж байна. Монгол хэл бичгийн судлагдахууны бүх багшийн заадаг ангиас чанарын үнэлгээний сорилго авахад 6-р анги 34 хүүхэд хамрагдаж 70,2% 7-р ангид 310 сурагч 55,2% 8-р ангид 299 сурагч 65,7% 9-р ангид 277 сурагч 60,1% 10- | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | р анги 314 сурагч 61,8% 12-р ангид 496 сурагч 75%-тай нийт 64,7%-ийн дундаж үнэлгээтэй байна. Төрийн албан хаагчдын монгол бичгийн чадварыг нэмэгдүүлэх зорилготой “Алтан хонх” уралдааныг Жангар номын сантай хамтран зохион байгуулж, шүүгчээр ажилласан. Тус уралдаанд 13 байгууллагын баг оролцсон. Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа 163 төрийн байгууллагын архив, албан хэрэг хөтлөлт хариуцсан ажилтан, Бичиг хэргийн эрхлэгч нарыг чадавхжуулах сургалтад “Төрийн албан хэргийг хос бичгээр хөтлөх тухай” агуулгаар оролцсон. Үндэсний бичиг үсгийн өдрийг тохиолдуулан төрийн албан хаагчдын дунд “Цахим монгол бичгийн уралдаан” зохион байгуулахад 21 байгууллагын албан хаагчид оролцсон. | |
| 1.3.4 | “Багш- Эрдэнэ” арга хэмжээг Боловсрол, шинжлэх ухааны газартай хамтран зохион байгуулна. | ОНТ | Арга хэмжээний тоо | 1 | 1 | Аймгийн Засаг даргын нэрэмжит анги нийтийн сорилгод 59 төрлийн хичээлээр 755 багшийн давхардсан тоогоор 28000 хүүхдийг хамруулан зохион байгуулсан. Шалгалтын үр дүнд ерөнхий дундаж гүйцэтгэл 60.7% байна. Үүнээс 330 багш 65%-с дээш үнэлгээтэй шалгагдсан. Анги нийтийн сургалтыг ахиулж 65%-иас дээш үнэлэгдсэн багш нарыг шагнаж урамшуулах, багшийн нийгмийн баталгааг хангах чиглэлээр "Оюунаараа манлайлъя" "Багш-Эрдэнэ" ёслол хүндэтгэлийн арга хэмжээнүүдийг зохион байгуулж 175 сурагч, 24 баг, анги хамт олон, 90 оюутан, 79 багш 13 байгууллагыг нийт 433.6 сая төгрөгөөр урамшуулсан байна. | 100 |
| **1.4. Соёл, урлаг, залуучууд, аялал жуулчлалын чиглэлээр:** | | | | | | | |
| 1.4.1 | Соёлын салбарын хүний нөөцийг хөгжүүлж, нийгмийн баталгааг хангахад дэмжлэг үзүүлнэ. | ОНТ | Дэмжлэг үзүүлсэн албан хаагчийн тоо | 10 | 5 | Аймгийн нийт соёлын төв, ерөнхий боловсролын сургууль, сургуулийн өмнөх боловсролын хөгжмийн багш, техникийн ажилчдыг чадавхжуулах сургалтыг 02 дугаар сарын 08-ны өдөр “Саунд мюзик студи”-тэй хамтран, тус студийн захирал, МУСТА, мэргэжлийн тоон мистер, хөгжмийн багш Г.Одгэрэлээр удирдуулан зохион байгууллаа. Тус сургалтыг “Онолын суурь мэдээлэл”, “Практик дадлага ажил”, “Тоног төхөөрөмж засварлах”, “Дуу, шуум, гэрэлтүүлэг” сэдвүүдийн хүрээнд зохион байгуулсан бөгөөд нийт 66 албан хаагчийг хамруулж, батламжийг гардууллаа.<br>Эх бэлтгэл, видео эвлүүлгийн сургалтыг “Атга чихэр” студитэй хамтран 2025 оны 03 дугаар сарын 20, 21-ний | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | өдрүүдэд зохион байгуулж, соёлын салбарын нийт 18 албан хаагч хамрагдаж байгууллагынхаа үйл ажиллагааг сурталчлан таниулах олон нийтэд түгээх эх бэлтгэн, видео эвлүүлэг хийх чадварыг эзэмшлээ.<br>Соёл, урлаг аялал жуулчлал залуучуудын газраас "Төрийн албан хаагчдад орон сууцны дэмжлэг үзүүлэх" хөтөлбөрт 2 албан хаагчийг хамруулахаар ажиллаж байна. Мөн сумдын соёлын төвөөс орон сууцны дэмжлэг хүссэн 15 албан хаагчийн материалыг аймгийн Засаг даргад уламжлаад байна.<br>Аймгийн Засаг даргын Тамгын газар Ардын дуу бүжгийн Алтай чуулгын 3 уран бүтээлчийн шинэ уран бүтээлийн зардалд аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс 14,0 сая төгрөгийн дэмжлэг үзүүллээ. | |
| 1.4.2 | "Нүүдэлчин" дэлхийн соёлын фестивальд орон нутгийн соёлын ондоошил брэнд үйлчилгээг сурталчлан оролцоно. | УТ,ОНТ | Хэрэгжилтийн хувь | 100 | Орон нутгийн оролцоог хангаж оролцсон байна. | "Нүүдэлчин" дэлхийн соёлын фестиваль 08 дугаар сарын 22-24-ний өдрүүдэд Улаанбаатар хотын Налайх дүүргийн нутаг дэвсгэрт байрлах "Тайж хайрхан"-ны бэлд зохион байгуулагдаж 40 хүний бүрэлдэхүүнтэй оролцлоо. "Алтай магтаал", "Жангар" туулийн удиртгал хэсэг болон "Агийн улаан хаан" туулийг тус тус хайлан, их тайзны 40 минутын тоглолт 1 удаа, өтгийн 35 минутын тоглолтыг 27 удаа тоглож давхардсан тоогоор 1600 гаруй ард иргэд үзэж сонирхлоо. Фестивальд оролцоход улсын төсвөөс 18,0 сая, орон нутгийн төсвөөс 5,6 сая, нийт 23,6 сая төгрөгийг зарцууллаа. | 100 |
| 1.4.3 | "Туульсын хаан Жангар" арга хэмжээг зохион байгуулна. | ОНТ | Хэрэгжилтийн хувь | 3 | 1 | Орон нутгийн онцлог бүхий соёлын бүтээгдэхүүн, үйлчилгээг хөгжүүлэх зорилгоор жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг "Туульсын хаан Жангар-2025" өв соёлын наадмыг жил бүрийн 12 дугаар сарын 21-ний өдөр зохион байгуулж хэвшээд байна.<br>Энэ жилийн наадамд ерөнхий боловсролын сургуулийн 680 сурагч , 80 бие биелээч, 240 товшуур хөгжимчид оролцуулан Алтай хотноо 4 дэх удаагаа зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна.<br>Энэ удаагийн арга хэмжээнд ОНТ-өөс 106,0 сая төгрөг зарцуулахаар төлөвлөлөө.<br>Мөн наадмын хүрээнд өв соёлын үзэсгэлэн зохион байгуулагдах бөгөөд орон нутгийн соёлын брэнд бүтээгдэхүүн үйлдвэрлэгч нийт 20 гаруй иргэн, хуулийн этгээд оролцохоор бүртгүүлээд байна. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1.4.4 | “Жангар фесиваль”-ийг зохион байгуулна. | ОНТ | Арга хэмжээний тоо | 3 | 1 | Залуучуудын гэр бүл төлөвлөлт, нөхөн үржихүй, эрүүл мэнд, цус ойртолт ба угийн бичиг хөтлөхийн ач холбогдол, үнэт зүйл амьдрах ухааны мэдлэг, мэдээллийг нэмэгдүүлэх, тэдний нийгмийн идэвхтэй оролцоог дэмжиж, хүн амын удмын сангийн аюулгүй байдлыг хамгаалах, зэргэлдээх аймгуудын залуусыг өөр хоорондоо танилцан, найзалж нөхөрлөх, харилцаа тогтоох боломжийг бүрдүүлэх зорилгоор Жангар фестиваль-IV залуучуудын нэгдсэн арга хэмжээг аймгийн Засаг даргын ивээл дор 2025 оны 07 дугаар сарын 24-26-ны өдрүүдэд зохион байгуулж, 1200 залуу хамрагдлаа. | 100 |
| 1.4.5 | Залуучуудын хувь хүний хөгжлийг дэмжиж, хорт зуршил, дэлгэцийн хамаарлаас урьдчилан сэргийлж, соён гэгээрүүлнэ. | УТ, ОНТ | Арга хэмжээний тоо | - | 5 | “Эх оронч Монгол-өвлөн наадъя” танин мэдэхүйн уралдаант тэмцээнийг 2025 оны 02 дугаар сарын 20-ны өдөр зохион байгуулж, зохион байгуулж аймаг, сумын нийт 12 сургуулийн 120 гаруй ахлах ангийн сурагчдыг оролцуууллаа.<br>“Говь нутгийн ганган хос шалгаруулах уралдаан”-ыг 01 дүгээр сарын 19-ний өдөр “Мөнгөн шаглаа”-2025 арга хэмжээний хүрээнд, 05 дугаар сарын 26-ны өдөр Төрийн үйлчилгээг иргэдэд хүргэх нээлттэй хаалганы өдөрлөгийн хүрээнд тус тус зохион байгуулж нийт 110 иргэд хамрагдаж, шагналт байруудыг урамшууллаа.<br>Эх орныхоо бахархалт соёл, түүний дотор эх хэл, уламжлал, зан заншил, мэдлэг ухаан, байгаль орчин зэрэг биет болон биет бус соёлын өвийг сурталчлан таниулах, залуу гэрэл зурагчдыг дэмжих тэдний бүтээлийг эдийн засгийн эргэлтэд оруулах, гэрэл зургаар Монгол Улсыг сурталчлах зорилгоор PHOTO WEEK 2025 арга хэмжээг 04 дүгээр сарын 28-ны өдөр зохион байгууллаа. Үзэсгэлэнг аймгийн “Жангар музей”, Гэрэл зургийн Говь-Алтай аймаг дахь салбартай хамтран дэглэж олон нийтэд хүргэж нийт 380 гаруй иргэд, сурагчдын төлөөлөл үзэж сонирхлоо.<br>Залуу багш нарын мэргэжил, ур чадварыг дээшлүүлэх, багшийн хөгжилд дэмжлэг үзүүлэх зорилгоор Дэлгэр сумын ерөнхий боловсролын сургуулийн залуу багш нарын дунд ур чадварын уралдааныг 05 дугаар сарын 16-ны өдөр зохион байгуулж нийт 24 багш хамрагдаж, шилдгүүдийг шалгаруулж урамшууллаа. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1.4.6 | Орон нутагт эрэлттэй мэргэжлээр суралцаж байгаа оюутнуудад төлбөрийн дэмжлэг үзүүлнэ. | ОНТ | Дэмжлэг үзүүлсэн оюутны тоо | - | 20 | “Боловсролын чанарыг сайжруулах хөтөлбөр"-ийн хүрээнд 2025 оны элсэлтийн шалгалтын дүнгээр 650-800 оноо авч, их дээд сургуульд элсэн орсон 107 оюутанд нийт 316,0 сая төгрөгийн дэмжлэг үзүүллээ. | 100 |
| 1.4.7 | Байгалийн нөөцөд тулгуурлан, нутгийн иргэдэд түшиглэсэн, зорилтот аяллыг сурталчилж, бүтээгдэхүүн, үйлчилгээг нэмэгдүүлнэ. | УТ,ОНТ | Бүтээгдэхүүн үйлчилгээний тоо | - | 5 | Аймгийн аялал жуулчлал 2024-2028 оны хөгжлийн хөтөлбөрийг боловсруулан ажиллаж байгаа бөгөөд тус хөтөлбөрт аялал жуулчлалын өрсөлдөх чадварын индексийг дээшлүүлэх арга хэмжээг тусган хэрэгжүүлэхээр ажиллаж байна.<br>“Мөсний баяр-2025” арга хэмжээг 2025 оны 1 дүгээр сарын 18-ны өдөр Есөнбулаг сумын Олон нуурт зохион байгууллаа. Мөсний баярын хүрээнд төрийн байгууллагуудын дунд олон төрөлт тэмцээнүүдийг зохион байгуулж, байгалийн үзэсгэлэнт газрууд, аялал жуулчлалын бүс нутгуудыг сурталчлах үзэсгэлэнг дэлгэн ард иргэдэд сурталчлан ажиллалаа. Соёл, урлаг, аялал жуулчлал, залуучуудын газар аймгийн аялал жуулчлалын холбоо хамтран “Үлэмжийн тансаг хөглөгөр их Алтай” танилцах аяллыг 2025 оны 05 дугаар сарын 02-ны өдрөөс 16-ны өдрүүдэд “Аялал жуулчлалын тур оператор компаниуд”-ыг хамруулан зохион байгууллаа. Аялал жуулчлалын салбарын нэгдсэн “Боломж ба шийдэл” анхдугаар зөвлөгөөнийг 2025 оны 05 дугаар сарын 27-ны өдөр зохион байгууллаа. Зөвлөгөөнд сум бүрийн Засаг дарга, Засаг даргын Тамгын газрын дарга нар, малчдын төлөөлөл, аж ахуй нэгжүүдийн төлөөлөл, аймгийн төвийн зочид буудал, ресторан, амралт сувиллын үйлчилгээ үзүүлдэг иргэд нийт 100 гаруй төлөөлөгч оролцож, аялал жуулчлалын салбарын өнөөгийн нөхцөл байдал, тулгамдаж буй асуудлууд, цаашид хэрэгжүүлэх бодлого, хөгжлийн хөтөлбөрүүдийг хэлэлцлээ.<br>Мөн “Их нүүдэлчдийн эрин” ХХк-тай гэрээ байгуулан аймгийн аялал жуучлалын нэгдсэн платформтой болох ажлыг зохион байгуулж байна.<br>Ээж хайрхан ууланд САКУРА /Буйлс/ цэцэглэхийг үзэх, Ээж хайрхандаа хүслээ даатгах 1 шөнө 2 өдрийн нэгдсэн аяллыг 2025 оны 05 дугаар сарын 03-ны өдөр зохион байгуулж, 8 хүн хамрагдлаа. | 100 |
| **1.5. Хүүхэд, гэр бүлийн чиглэлээр** | | | | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1.5.1 | Хүүхэд, гэр бүлд чиглэсэн "Хамтын шийдэл-Хамгаалагдсан ирээдүй" арга хэмжээг боловсруулан батлуулж, хэрэгжилтийг хангаж ажиллана. | УТ,ОНТ | Хэрэгжилтийн хувь | - | 30 | Хүүхдийн эрх, аюулгүй байдлыг хангаж ажиллах ажлын хэсгийг аймгийн Засаг даргын А/178 дугаар захирамжаар байгуулж, тус ажлын хэсгээр ЗДҮАХ-т тусгагдсан "Хамтын шийдэл-Хамгаалагдсан ирээдүй" арга хэмжээг хэлэлцлээ. Мөн "Хүүхдийн байгууллага, хөдөлгөөн үүсч хөгжсөний түүхт 100 жилийн ой"-г тохиолдуулан тус салбарт ажиллаж байсан ахмад ажилтнууд, үе үеийн удирдлагууд, хамтран ажилладаг төрийн байгууллагууд, хүүхдийн хөгжил, хамгааллын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагууд, сум багийн хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтнууд, боловсролын нийгмийн ажилтнуудыг оролцуулан "Хамтын шийдэл- Хамгаалагдсан ирээдүй" хэлэлцүүлэг, уулзалт зохион байгуулж, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээ, анхаарах асуудлын талаар санал бодлоо солилцлоо. 2025.05.19-ны өдөр Хүний эрхийн үндэсний комиссын аймгийн референттэй хамтран "Хүүхдийн эрх" сэдэвт хэлэлцүүлгийг зохион байгууллаа. 2025.06.18-ны өдөр "Хүүхэд-хайр-ирээдүй" үүрэг хүлээгчдийн зөвлөгөөнийг зохион байгуулж, 18 сум 2 тосгоны ИТХ-н дарга, Засаг дарга, ЕБС-иудын захирал, цэцэрлэгийн эрхлэгч, хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтнууд нийт 150 хүн оролцож, хүүхэд хамгааллын тухай хуулийн хэрэгжилт, хүүхэд, гэр бүлийг болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хүүхдийн өмнө хуулиар үүрэг хүлээсэн үүргийн талаар хэлэлцүүлэг хийлээ.Дээрх 4 удаагийн хэлэлцүүлгээс гарсан санал хүсэлтийг уг арга хэмжээнд тусган сайжруулж, аймгийн Засаг даргын удирдлагын зөвлөлөөр хэлэлцүүллээ. Хүүхэд, гэр бүлийн чиглэлээр төрөөс баримталж буй бодлого шийдвэрийг орон нутагт хэрэгжүүлэх, хүүхдийн эрхийг хангах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, аюулгүй байдлыг хангах, салбар дундын уялдаа холбоог сайжруулж, дэмжих зорилгоор "Хамтын шийдэл–Хамгаалагдсан ирээдүй" хүүхдийн хөгжил, хамгааллын хөтөлбөрийг 4 зорилт, 26 үйл ажиллагаа, 27 шалгуур үзүүлэлттэйгээр аймгийн ИТХ-ын 2025 оны 08 дугаар сарын 21-ны өдрийн 37 дугаар тогтоолоор баталлаа. | 100 |
| 1.5.2 | "Засагт ханы хот айл гэр зуслан"-г сумдад байгуулж, | ОНТ | Амрагч хүүхдийн тоо | 200 | 250 | "Засагт ханы хот айл" зусланг бүсчилсэн хэлбэрээр зохион байгуулахаар аймгийн Хүүхдийн төлөө зөвлөлийн хурлаар шийдвэрлэлээ. Аймгийн Засаг | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | монгол ахуй, ёс заншил, амьдрах ухаанд сургах зуслангийн хөтөлбөрийг хэрэгжүүлнэ. | | | | | даргын баталсан удирдамж болон чиглэл хүргүүлэх тухай Засаг даргын 2025 оны 06 дугаар сарын 04-ний өдрийн 1/796 тоот албан бичгийг сумдууд хүргүүлж, зуслан байгуулах бэлтгэл ажлыг хангаж ажилах талаар үүрэг чиглэлийг өглөө. Сумдад гэр зуслангийн үйл ажиллагааг 2025 оны 6 дугаар сарын 20-ны өдрөөс 7 дугаар сарын 5-ны өдөр хүртэл 1,2 дахь ээлжийг, 7 дугаар сарын 23-ны өдрөөс 7 дугаар сарын 30 хүртэл 3 ээлжээр зохион байгууллаа. Засагт ханы хот айл зусланг бүсчилсэн хэлбэрээр зохион байгуулж, 390 хүүхэд хамрагдсанаас зорилтот бүлгийн 110, үүнээс хөгжлийн бэрхшээлтэй 27 хүүхэд байна. | |
| 1.5.3 | Хүүхдийн төлөө зөвлөлийн үйл ажиллагааг тогтмолжуулан, хуулиар хүлээсэн чиг үүргийн биелэлтийг хангах, арга зүйн дэмжлэг үзүүлж, ажлын үр дүнг тайлагнана. | УТ,ОНТ | Хэрэгжилтийн хувь | 90 | 100 | Хүүхдийн төлөө зөвлөлийн 2024 оны төлөвлөгөөний тус хэлтэстэй холбоотой заалтын биелэлтийг гаргаж, Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газарт хүргүүллээ. Аймгийн Засаг даргын 2025 оны 02 дугаар сард Хүүхдийн төлөө зөвлөлийн хурлыг Хүүхдийн эрхийн хууль зүйн хороотой хамтатган өргөтгөсөн хэлбэрээр зохион байгуулж, хурлаар 2024 оны байдлаар хүүхэд үйлдсэн гэмт хэргийн шалтгаан, хохирогч хүүхдийн талаарх мэдээлэл мөн Хүүхдийн төлөө зөвлөлийн 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг хэлэлцэн баталлаа. Хүүхдийн төлөө зөвлөлөөс хүүхдийн эрх, хамгааллын салбар дундын төлөвлөгөөг 3 зорилтын хүрээнд 21 арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталж, хэрэгжилт 91.8%-тай байна. Тус зөвлөл хүүхдийн баярын арга хэмжээг тэмдэглэн өнгөрүүлэх, “Засагт ханы хот айл” гэр зуслан ажиллуулах, "Хамтын шийдэл-хамгаалагдсан ирээдүй" хүүхдийн хөтөлбөр батлуулах, аймгийн хүүхэд, гэр бүлийн чиглэлээр орон нутагт хийж буй ажлын үр дүн, зөвлөлийн 2025 оны төлөвлөгөөний биелэлт, 2026 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа, гишүүн байгууллагуудын мэдээлэл зэрэг асуудлуудыг хэлэлцлээ. 2025 онд дараах ажлуудыг хийлээ. Үүнд: "Цодгор хүү" шатрын аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг 2025 оны 1 дүгээр сарын 04-05-ны өдрүүдэд зохион байгуулж, 90 гаруй хүүхэд оролцож, шагнаж урамшууллаа. Эрдэнэ, Чандмань сумдад ажиллаж, сургалт зохион байгуулан хүүхэд хамгааллын үйлчилгээг үзүүллээ. Хүүхдийн элчийг мэргэжил арга зүйгээр хангах, чадавхжуулах, харьяа сумынхаа хүүхдийн эрх, хамгааллын асуудлаар | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | санал, хүсэлт, өргөдөл, гомдлыг холбогдох ажилтан, байгууллагад тавьж шийдвэрлүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах, хүүхэдтэй ажиллах ур чадвараа нэмэгдүүлэхэд нь зөвлөн туслах зорилгоор Хүүхдийн элч нарыг чадавхжуулах сургалтыг зохион байгууллаа.<br>Сар шинийн баярыг угтан өсвөр үе, хүүхэд, залуучуудад эх оронч үзэл төлөвшүүлэх, Монголын уламжлалт ёс заншил, зан үйл, тоглоом наадгайг түгээн дэлгэрүүлэх, өвлүүлэх, сурталчлан таниулах, түүх, соёлын өвийг хамгаалах, багаар ажиллах чадварыг нэмэгдүүлэх зорилгоор "Эх оронч монгол-өвлөн наадъя" танин мэдэхүйн уралдаант нөлөөллийн ажлыг зохион байгуулж 182 хүүхдийг хамруууллаа.<br>Оролцооны байгууллагуудын үйл ажиллагааг идэвхжүүлэх, хүүхэд багачуудад монгол ёс заншлыг сурталчлан таниулах, тэднийг зөв зүйлд уриалан дуудах зорилгоор Контент, рийл хийх уралдааныг Хүүхдийн зөвлөл, Мэдлэгийн өртөө клубуудын дунд зохион байгууллаа. Аймгийн 15-18 насны хүүхэд залуучуудыг хамруулан "Youth power Говь-Алтай" байгальд ээлтэй хүүхдийн чуулганыг 2025.4.22-ны өдөр зохион байгуулж, 18 сум, 2 тосгоны нийт 90 хүүхэд оролцлоо. Мөн Тонхил, Баян-Уул, Есөнбулаг сумын ерөнхий боловсролын сургуулиудын 390 хүүхдийг хамарсан "Сургуулийн орчин дахь асуудал" сургалт, нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулж, сургалт, илтгэл, хэлэлцүүлэг өрнүүлж, "Сургуулийн орчин дахь асуудал" эссэ бичлэгийн уралдаан зарлаж шилдгүүдээ шагнаж урамшууллаа. Тус зөвлөл 2025.05.29-нд хуралдаж хүүхдийн баярын арга хэмжээг тэмдэглэн өнгөрүүлэх, "Засагт ханы хот айл" гэр зуслан ажиллуулах, хүүхдийн байгууллага хөдөлгөөн үүсэж хөгжсөний 100 жилийн ойн төлөвлөгөө гэсэн 3 асуудал хэлэлцлээ. Мөн тус зөвлөлөөс спорт, урлаг, уралдаан тэмцээнд амжилт гаргасан хүүхдүүдийг шагнаж урамшуулах асуудлыг хэлэлцэн баталж, уг арга хэмжээнд 166 хүүхдэд 268,0 сая төгрөг олголоо. Мөн хүүхдийн хөгжил оролцоог дэмжих, хамгаалах зорилгоор "Ид шидийн орон" хүүхэд хөгжил, хамгааллын төвийн үйл ажиллагаанд 45.0 сая, скаутын | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | холбоонд бүлгийн удирдагч бэлтгэх анхан шатны сургалтад оролцоход 3,4 сая, хүүхэд хөгжлийн “Майхант цугларалт” арга хэмжээнд оролцсон аймгийн хүүхдийн төлөө зөвлөлд 1,8 сая, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбар комисст 2,0 сая төгрөг, сургалт зөвлөгөөн зохион байгуулахад 20,0 сая төгрөгийн дэмжлэгийг тус тус үзүүллээ. Хүүхдийг ивээх сантай хамтран “Хүүхэд хамгааллын асуудал, шийдэл” чуулга уулзалтыг зохион байгуулж, 100 гаруй хүн оролцож, хамтран ажиллах бодлогоо тодорхойллоо. | |
| 1.5.4 | Гэр бүлд зөвлөгөө өгөх төвөөр дамжуулан гэр бүлд чиглэсэн олон талт нөлөөллийн арга хэмжээг хэрэгжүүлнэ. | УТ,ОНТ | Хамрагдсан гэр бүлийн хувь | 10 | 15 | Япон Улсын Засгийн газрын “Өвсний үндэс” хөтөлбөрийн хөрөнгөөр “Түр хамгаалах байр”-ыг барьж ашиглалтад оруулж, тус байрны зохицуулагч, менежер, нийгмийн ажилтан, сэтгэл зүйч, үйлчлэгч-тогооч гэсэн 5 хүнийг томилон үйл ажиллагаа хэвийн явагдаж, урсгал зардал болон үйлчилгээний зардалд орон нутгаас 119,0 сая төгрөгийг шийдвэрлэлээ. “Түр хамгаалах байр”-нд хүүхэд 25, насанд хүрэгч 7 нийт 32 хүнийг аюулгүй байдлын хамгаалалтад авч, үйлчилгээг төлөвлөн үзүүлж, хохирогчийг гэр бүлд нь эргэн нэгтгэж ажиллалаа. Дэлхийн гэр бүлийн өдрийг тохиолдуулан гэр бүлийн зэрэг харицааг бий болгох, эцэг эхийн хамтын үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх, өрх бүр угийн бичиг хөтлөх, гэр бүлийн боловсролоор дамжуулан гэр бүлийн хөгжил, хамгаалал, оролцоог бэхжүүлэх зорилгоор “Гэр бүл–Гэрэлт ирээдүй” сарын аянг аймгийн хэмжээнд зохион байгуулж, 17 төрлийн арга хэмжээнд 3260, гэр бүлийн боловсрол олгох 8 модуль сургалт, нөлөөллийн арга хэмжээнд 6532 хүнийг хамрууллаа. Аймгийн хэмжээнд ажиллаж буй 30 хамтарсан баг гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 68 удаагийн сургалт, нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулж, 3470 хүнийг хамрууллаа. Гэр бүлийн боловсрол олгох сургалт нөлөөллийн арга хэмжээнд нийт 2500 гэр бүл, 9792 иргэн хамрагдлаа.<br>“Гэр бүлд зөвлөгөө өгөх төв”-ийн нийгэм, сэтгэл зүйн зөвлөгөө үйлчилгээнд хүүхэд 91, насанд хүрэгч 62 нийт 153 хүнийг хамрууллаа. Хүчирхийлэл үйлдэгчийн зан үйлд нөлөөлөх 26 удаагийн албадан сургалтад 100 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | иргэнийг, “Хоригдол суллахад бэлтгэх хөтөлбөр”-т тусгагдсан арга хэмжээний хүрээнд 10 удаагийн сургалт, 23 удаагийн сэтгэл зүйн зөвлөгөө үйлчилгээ нийт 33 удаагийн үйл ажиллагааг 7 хоног бүр 4 хоригдолд үзүүлэн ажиллалаа. Хүүхэд хамгааллын явуулын үйлчилгээний хүрээнд 2026 онд гэр бүлийн хөгжлийн цогц үйлчилгээний төв ажиллуулах заавар зөвлөмжийг 18 сум, 2 тосгоны хэмжээнд танилцуулж, гэр бүлд үзүүлэх нийгмийн ажил үйлчилгээний орон нутгийн зураглалыг гаргах, хүний нөөц, санхүүгийн нөөцийг тодорхойлох ажлыг зохион байгууллаа. "Гэр бүлд зөвлөгөө өгөх төв"-өөр дамжуулан олон нийтэд гэр бүлийн боловсрол олгох сургалт, нөлөөллийн арга хэмжээнд 2500 гэр бүл, 9792 иргэнийг хамруулсан нь нийт өрхийн 15.2%-ийг эзэлж байна. | |
| 1.5.5 | Иргэний нийгмийн байгууллагын үйл ажиллагаанд санхүүгийн дэмжлэг олгож, хамтран ажиллана. | ОНТ | Хамтран ажилласан байгууллагын тоо | 4 | 5 | “Төр, төрийн бус байгууллагын түншлэл” сургалт, уулзалтыг 2025 оны 02 дугаар сарын 03-ны өдөр зохион байгуулж, аймгийн Засаг дарга, удирдлагууд, төр, төрийн бус байгууллагын төлөөлөл 60 гаруй хүн оролцлоо. Энэ уулзалтаар иргэний нийгэм болон төрийн бус байгууллагуудын саналыг сонсож харилцан ажиллах санамж бичгийн төслийг танилцуулж тэдний үйл ажиллагааны тайланг сонсож цаашид хамтран ажиллах чиглэлийг тодорхойллоо.<br>Аймгийн Засаг даргын Тамгын газар ахмадын хороотой гэрээ байгуулан ахмад настнуудад мэдээ, мэдээлэл, сургалт, сурталчилгаа, хүндэтгэлийн болон нөлөөллийн арга хэмжээг тогтмол зохион байгуулж, тэдний нийгмийн оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр хамтран ажиллаж, орон нутгийн төсвөөс 150.1 сая төгрөгийн санхүүжилт олгон, үйл ажиллагааг байнга дэмжин ажиллаж байна. “Хуулийн сургалт зохион байгуулах ажлыг “Хууль дээдлэх ёс” ТББ-тай 19.8 сая төгрөгийн гэрээ байгуулан гүйцэтгүүлж, аймгийн 26 төрийн байгууллагын удирдах албан тушаалтан, хүний нөөц, хууль, эрх зүйн мэргэжилтэн, нягтлан, 10 сумын Засаг даргын Тамгын газрын хууль, эрх зүй хариуцсан мэргэжилтнүүд оролцон туршлага судлав. Аймгийн эмэгтэйчүүдийн холбоонд “Ээж ментор” хөтөлбөрийг хэрэгжүүлж, 500 эмэгтэйд сургалт нөлөөллийн ажил зохион байгуулах үйл ажиллагаанд 4.5 сая төгрөг, "Ид шидийн орон" хүүхэд хөгжил, хамгааллын төвд 45.0 сая | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | төгрөг тус тус олголоо. “Алтайн ирвэсүүд” клубт өсвөр үеийн улсын аварга шалгаруулах тэмцээнд оролцоход нь 3,0 сая, аймгийн хөлбөмбөгийн холбооны футзалын улсын аварга шалгаруулах тэмцээнд оролцсон тамирчдад 14,0 сая, скаутын холбоонд бүлгийн удирдагч бэлтгэх анхан шатны сургалтад оролцох зардал 3,4 сая төгрөг, хүүхэд хөгжлийн “Майхант цугларалт” арга хэмжээнд оролцсон аймгийн хүүхдийн төлөө зөвлөлд 1.8 сая, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн аймгийн салбар зөвлөлд 3.4 сая төгрөгийн дэмжлэгийг тус тус үзүүллээ.Естийн аманд хүлэмжийн аж ахуй байгуулах ажлыг “Фермер эмэгтэйчүүдийн холбоо” ТББ-тай гэрээ байгуулан гүйцэтгэлээ. | |
| 1.6.Хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр | | | | | | | |
| 1.6.1 | Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр ажлын байр нэмэгдүүлэх, ажлын байрыг хадгалах, тогтвор суурьшилтай ажиллах нөхцөлөөр хангах чиглэлээр зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллах, ажилгүй иргэдийн судалгааг сумаар гарган, иргэдийн орлогыг нэмэгдүүлэх талаар оновчтой арга хэмжээ зохион байгуулж ажиллах, өрх бүрт ажлын байр бий болгох талаар дэмжиж ажиллана. | УТ,ОНТ | Шинэ ажлын байр | 1375 | 1380 | Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих ажлын хүрээнд уулзалт, өдөрлөг, хэлэлцүүлгийг зорилтот бүлэг бүрээр зохион байгуулж, ажил олгогчдын талаарх мэдээллийг өгч ажилласнаар байнгын 997, улирлын 150, түр 224, нийт 1371 шинэ ажлын байрыг бий болголоо. Шинээр бий болсон ажлын байрыг өмчийн хэлбэрээр нь авч үзвэл 206 нь төрийн, 31 орон нутгийн, 1134 хувийн байгууллагууд бий болсон байна.<br>Санхүүжилтийн эх үүсвэрээр нь авч үзвэл улсын төсвийн хөрөнгөөр 845, орон нутгийн хөрөнгөөр 31, гадаадын зээл тусламжаар 13, хувийн болон бусад эх үүсвэрээр 482 ажлын байр бий боллоо.<br>Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй 374 байгууллага, аж ахуйн нэгжээс 1075 сул чөлөөтэй ажлын байрны захиалга ирүүлсний дагуу ажилгүй, ажил хайгч 850 иргэнийг ажилд зуучиллаа.<br>Ажил, хөдөлмөр эрхлэх хүсэл сонирхолтой ажилгүй иргэдийг хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн систем EJOB программд бүртгэх, сэргээх үйлчилгээг тогтмол зохион байгуулж, ажил идэвхитэй хайж буй 1485 иргэн бүртгүүллээ.<br>Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах бүлгийн сургалтад 15 бүлгийн 670, ганцаарчилсан зөвлөгөө өгөх мэдээллээр хангах үйлчилгээнд 350, нийт 1020 иргэнийг хамруулаа. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | “Хөдөлмөрт бэлтгэх, хөдөлмөр эрхлэлтийн сургалтын үйл ажиллагаа”-нд 150 иргэнийг хамруулж ХЭДСангаас 6000,0 мянган төгрөгийг зарцуулллаа.<br>Үсчний мэргэжил олгох түр сургалтыг зохион байгуулж, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хөгжлийн бэрхшээлтэй гэр бүлийн гишүүнээ асарч буй 17 иргэн хамрагдаж ХЭДСангаас 3,4 сая төгрөгийг зарцуулллаа. Барилгын бетон арматур, засал чимэглэл, талх нарийн боовны үйлдвэрлэлийн технологи, хүнд машин механизмын оператор, хүлэмжийн аж ахуйн фермер гэсэн 5 төрлөөр 35 иргэн мэргэжлийн боловсролын сургалтад хамрагдан, хувиараа ажил эрхэлж байна. Аймагт дэд бүтэц, уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй компаниуд болон томоохон бүтээн байгуулалтад орон нутгийн иргэдийг ажиллуулах бодлогыг баримтлан ажиллаж "Цэн газар" ХХК-ийн нийт 111 ажилтны 52 буюу 46.8 хувь, "Хан Алтай ресурс" ХХК -ийн нийт 1010 ажиллагсдын 370 буюу 36.7 хувь, "Мандал-Алтай" ХХК-ийн нийт 27 ажилтан 100 хувь, "Цэрдийн тал" ХХК-д 1, "Секэр ресурс" ХХК-д 3, аймгийн хэмжээнд нийт 453 орон нутгийн ажиллагсад эзэлж байна. Эдгээрээс 38 нь хөгжлийн бэрхшээлтэй иргэн байна. | |
| 1.6.2 | Хөдөлмөр эрхлэлтийг дэмжсэн төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлнэ. | УТ,ОНТ | Хамрагдсан хүний тоо | 700 | 750 | 2025 онд хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр хэрэгжих төсөл хөтөлбөр болон төсвийн талаар Хөдөлмөр эрхлэлтийн аймгийн салбар зөвлөлд танилцуулллаа. Энэ онд Хувиараа хөдөлмөр эрхлэгч 25 ба түүнээс дээш хөдөлмөрийн насны 48 иргэнд ХЭДСангаас 523,0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэгийг 36 сарын хугацаатай олгож, 48 ажлын байр шинээр бий боллоо.<br>Хувиараа хөдөлмөр эрхлэгч 45 ахмадад ХЭДСангаас 250000,0 мянган төгрөгийн санхүүгийн дэмжлэгийн 24 сарын хугацаатай олгож, 45 ажлын байр бий боллоо.<br>Санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй 18, хөгжлийн бэрхшээлтэй гэр бүлийн гишүүнээ асарч байгаа 4, нийт 22 иргэнийг хамруулж ХЭДСангаас 160,000 мянган төгрөгийг 50 хувийн буцаан төлөх нөхцөлтэй, 36 сарын хугацаатай олгож, 22 ажлын байр шинээр бий боллоо.<br>Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг боловсрол, соёл урлаг, эрүүл мэнд, спортын чиглэлээр зохион байгуулж, 15 сум 1 тосгоны 58 ахмадыг хамруулж, ХЭДСангаас 62600,0 мянган төгрөг зарцуулллаа. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Малжуулах арга хэмжээнд 19 сумын 36 өрхийг хамруулж, ХЭДСангаас 288.0 сая төгрөгийг зарцуулж, 36 ажлын байр бий боллоо.<br>Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд 18-34 хүртэлх насны 7 залуучууд хамрагдаж ХЭДСангаас 80.0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэгийг олголоо. Түр ажлын байраар 194 иргэн хангагдаж, ХЭДСангаас 126.6 сая төгрөгийг зарцууллаа. | |
| 1.6.3 | Хөдөлмөр эрхлэлтийн аймгийн зөвлөлийн үйл ажиллагааг идэвхжүүлж, орон нутгийн онцлогт тохирсон хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна. | УТ,ОНТ | Хэрэгжилтийн хувь | 100 | 100 | Хөдөлмөр эрхлэлтийн орон нутгийн зөвлөл нь 3 удаа хуралдаж тухайн онд хийж хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө, гишүүдийн чиг үүргийг батлахаас гадна тайлант онд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр хэрэгжүүлэх үйл ажиллагаа, 2025 оны ХЭДСангийн төсөвтэй танилцаж, санал солилцлоо. Тус зөвлөлөөс санаачлан “Хөдөлмөрөөр өөрчлөлтийг эхлүүлцгээе” нээлттэй өдөрлөгийг зохион байгуулж, зөвлөлийн нарийн бичгийн дарга буюу хөдөлмөр эрхлэлтийн хэлтсийн дарга “2025 онд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр арга хэмжээний танилцуулга”-ын талаар иргэдэд мэдээлэл хийж, санал хүсэлтийг нь сонслоо. Монголын уламжлалт цагаан сарын баярыг угтан “Халуун сэтгэл” хандивын аяныг 1 сарын хугацаанд санхүүгийн дэмжлэг авсан иргэдтэй хамтран зохион байгуулж, зорилтот бүлгийн нэг өндөр настан болон 3 хүүхэдтэй өрх толгойлсон нэг эцгийг сонгон авч дээл хувцас, ахуйн болон хүнс өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний тусламж дэмжлэг үзүүллээ.<br>“Монгол эв нэгдэл” төслийн хүрээнд “Алтайд үйлдвэрлэв” борлуулалтын төвийг олон нийтэд сурталчлан таниулах зорилгоор хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн байршуулсан бараа бүтээгдэхүүний үзэсгэлэнг гаргаж, цахимаар сурталчиллаа. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас санхүүгийн дэмжлэг олгох төсөл сонгон шалгаруулах ажлын хэсэгт орж ажиллан 2025.05.07-05.09-ны хооронд Есөнбулаг сумын 25-аас дээш насны хувиараа хөдөлмөр эрхэлдэг санхүүгийн дэмжлэг хүссэн төсөл ирүүлсэн 24 иргэн, хөгжлийн бэрхшээлтэй 12 иргэн нийт 36 иргэний ажлын байраар явж, үйл ажиллагаатай танилцаж, үнэлэлт дүгнэлт өглөө. Тус ажлын хэсэг төсөл хөтөлбөрт хамрагдсан иргэдийн талаарх мэдээллийг ажлын хэсэгт | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | танилцууллаа. 2025 онд төсөл авсан иргэдийн үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүн, үзүүлж буй үйлчилгээний талаарх үзэсгэлэн худалдааг зохион байгуулж, олон нийтэд сурталчиллаа. 2025 оны 10 сард төслөө ирүүлсэн 15 иргэний ажлын байртай танилцаж шалгаруулан санхүүгийн дэмжлэг олголоо. Зөвлөл 3 дахь хуралдаанаа 2025 оны ХЭДСангийн гүйцэтгэл, ажлын тайлантай танилцаж мэргэжил арга зүйн дэмжлэгийг үзүүлэн ажиллалаа. Мөн 2026 онд ХЭДСангийн санхүүгийн дэмжлэгийг орон нутгийн тэргүүлэх чиглэлтэй уялдуулах, өмнөх онуудад дэмжлэгт хамрагдсан иргэдийн үйл ажиллагаатай танилцах хяналт хийх зөвлөмжийг хүргүүллээ. | |
| 1.6.4 | ХАБЭА-н зөвлөлийг тогтмол хуралдуулж, үйл ажиллагааны төлөвлөгөөг батлуулж хэрэгжүүлэн ажиллана. | УТ,ОНТ | Хэрэгжилтийн хувь | 100 | 100 | Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөлийг аймгийн Засаг даргын 2025 оны 01 дүгээр сарын 29-ны өдрийн А/29 дүгээр захирамжаар шинэчлэн байгууллаа.Тус зөвлөл нэг удаа хуралдаж, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн улсын үзлэгийг орон нутагт зохион байгуулсан дүн мэдээг хэлэлцэж, үзлэгийн явцад илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах талаар аймгийн Засаг даргын захирамж гаргаж, сум байгууллагуудад хүргүүллээ. "Хөдөлмөрөөр өөрчлөлтийг эхлүүлцгээе" нээлттэй өдөрлөгийг зохион байгуулж, тус зөвлөлөөс "Хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн харилцаа, хөдөлмөрийн аюулгүй байдал" сэдвээр танилцуулга, мэдээллийг иргэдэд хийлээ. Зөвлөл 2025 оны 03 дугаар сарын 28-ны өдөр хуралдаж, жилийн ажлын төлөвлөгөө болон сарын аяны төлөвлөгөөг хэлэлцэн баталлаа. Энэ жил сарын аяныг "Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн хөгжил-Хиймэл оюуны хэрэглээ ба цахимжилт" уриатайгаар нээлтийн арга хэмжээг 04 дүгээр сарын 01-ний өдөр төв талбайд зохион байгуулж ажиллалаа. Аяны нээлтийн үеэр "Онцгой байдлын газар", "Хан-Алтай ресурсс" ХХК, "Макс -Өргөө" ХХК, "АУЭХС" ТӨҮГазар ,Тайшир-Гуулин УЦС, Ундарга-Алтай ОНӨААТҮГазар, Алтай хотын тохижилт үйлчилгээний газар, Мандал-Голомт ХХК, Мэдээлэл холбоо сүлжээний газар зэрэг газрууд ажлын хувцас, тусгай хамгаалах хэрэгсэл, тэмдэг тэмдэглэгээ, хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн дүрэм журам, техник тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагаа зэрэг салбар бүрийн | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | аюулгүй ажиллагааны онцлогийг харуулсан үзэсгэлэн гаргаж ард иргэд болон бусад салбарын ажилтнуудад сурталчлан таниуллаа. УЦУОШТөвөөс зохион байгуулсан "Эртнээс сэрэмжлүүлэх тогтолцоонд учрах саад бэрхшээлийг хамтдаа шийдэцгээе" сэдэвт сургалт, хэлэлцүүлэгт оролцсон албан хаагчдад хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийг сурталчлан сургалт,зөвлөгөө мэдээлэл өглөө. "Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн үндэсний III чуулган"-д зөвлөлийн дарга, нарийн бичгийн дарга нарр оролцлоо. Хөдөлмөрийн хяналтын улсын байцаагч нар "Хан-Алтай Ресурс" ХХК-ийн мэргэжилтнүүдтэй хамтран хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтыг зохион байгуулж, аймгийн Цагдаагийн газар болон "Тайшир-Гуулин" УЦС ХХК-ийн инженер, техникийн ажилтнууд хамрагдлаа. Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд нарын хамтран баталсан "Аюулгүй барилга-Аюулгүй ажиллагаа" аяны удирдамжийн хүрээнд ГХБХБГ, ХХҮГ-ын дарга нарын хамтран ажиллах төлөвлөгөө, хяналт шалгалт хийх, зөвлөгөө мэдээлэл, сургалт сурталчилгаа хийх ажлын хуваарь зэргийг боловсруулан батлуулж, төлөвлөгөөний дагуу 4 барилга угсралтын талбайд ажиллан урьдчилан сэргийлэх шалгалт хийж, улсын байцаагчийн зөвлөмж хүргүүлэн, 40 ажилтанд сургалт мэдээлэл хийж ажиллав. Аяны нээлтийн арга хэмжээг 2025 оны 05 дугаар сарын 28-ны өдөр зохион байгуулж, барилгын салбарын ХАБ хариуцсан ажилтан нарыг мэргэшүүлэх сургалтыг зохион байгуулан 23 хүнийг хамруулав. Сургууль, цэцэрлэгийн хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуй хариуцсан албан хаагчдыг мэргэшүүлэх, мэргэшлийн сертификат олгох сургалтыг зохион байгуулж, аймаг, сумдын сургууль, цэцэрлэгийн ХАБЭА хариуцсан 132 албан хаагч хамрагдлаа. | |
| | 1.7. Нийгмийн хамгааллын чиглэлээр | | | | | | |
| 1.7. 1 | Нийгмийн халамжийн үйлчилгээг зорилтот бүлэгт | УТ,ОНТ | Хамрагдсан хүний тоо | 125 | 125 | Нийгмийн халамжийн тэтгэвэр 1440 иргэнд 5,885.6 сая, асаргааны тэтгэмж 1535 иргэнд 4,389.9 сая, амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмж 1452 иргэнд 940.9 сая, онцгой тохиолдлын мөнгөн тэтгэмж 17 иргэнд 20,4 сая, хүнс | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | чиглүүлэн, тэдний хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж ажиллана. | | | | | тэжээлийн дэмжлэг туслалцаа 1795 иргэнд 244.7 сая, жирэмсэн эхийн тэтгэмж 1075 хүнд 123,9 сая, 0-3 хүртэлх насны хүүхдээ асарч буй эх, эцгийн тэтгэмж 2537 иргэнд 1018.3 сая, ихэр хүүхдийн тэтгэмж 8 хүнд 16.0 сая, 3 ба түүнээс дээш хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцгийн тэтгэмж 145 иргэнд 287.1 сая, алдар цолтон ахмад настанд үзүүлсэн хөнгөлөлт 24 иргэнд 8.6 сая, хөгжлийн бэрхшээлтэй иргэний тусламж хөнгөлөлтөд 923 иргэнд 187.6 сая, насны хишиг 3158 иргэнд 500.8 сая, алдарт эхийн одонтой эхчүүдэд үзүүлэх мөнгөн тусламж 5462 эхэд 1368.9 сая, олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээнд 50 хүнд 81,6 сая тус тус олгож, нийт 19621 хүн халамжийн үйлчилгээнд хамрагдлаа. Мөн хүүхдийн мөнгөн тэтгэмжид 20826 хүүхэд хамрагдлаа.<br>"Хөдөлмөрөөр өөрчлөлтийг эхлүүлцгээе" өдөрлөгт оролцсон иргэдэд нийгмийн халамжийн үйл ажиллагааны мэдээлэл болон олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний талаарх мэдээллийг хүргэж, өмнөх онд бүлгийн төсөлд хамрагдсан Есөнбулаг, Тонхил, Дэлгэр сумдын иргэд үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн үйлчилгээгээ танилцууллаа.<br>Орон нутгийн онцлогт нийцсэн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, "Халамжаас-Хөдөлмөрт" шилжүүлэх зорилтыг хангах хүрээнд "Зорилтот өрх, иргэнийг хөгжүүлэх, чадавхжуулах, бие даан амьдрахад нь дэмжлэг үзүүлэх" үйлчилгээг шинээр нэвтрүүлж, бага орлоготой өрхийн тогтвортой амьжиргааг дэмжих ажлын төлөвлөгөөг 3 зорилт, 10 заалтийн хүрээнд боловсруулж, хэрэгжүүлэн 91,3-% хувьтай хэрэгжлээ.<br>Хүнсний эрхийн бичгийн үйлчилгээ хүртэгч хөдөлмөрийн насны иргэдийн судалгааг шинэчлэн гаргаж, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн төсөл хөтөлбөрийн мэдээлэл, сул чөлөөтэй ажлын байрны мэдээлэл хүргэлээ. Үүнээс 90 иргэнийг "Дэлхийн зөн ОУБ-ын Говь-Алтай орон нутгийн хөтөлбөр"-ийн газартай хамтран сургалт, нөлөөлийн ажилд хамрууллаа. Хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд хамрагддаг өрхөөс хөдөлмөрийн насны хөдөлмөрийн чадвартай иргэн 463, ажил эрхэлдэг 216, ажил хөдөлмөр эрхлээгүй 247 иргэн байна. Үүнээс: ХБИ -ний | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | санхүүгийн дэмжлэгт 1 иргэн 7,0 сая, хувиараа хөдөлмөр эрхлэгчийн санхүүгийн дэмжлэгт 1 иргэн 10,0 сая, малжуулах хөтөлбөрт 3 өрхийн 6 иргэн хамрагдаж 24,0 сая, ОНОТХҮ-ний бүлгийн төсөлд 21 иргэн хамрагдаж 37,8 сая төгрөгийн тоног төхөөрөмж, түүхий эд материал олгосон.Үсчний мэргэжил олгох сургалтад 2 иргэнийг хамруулж мэргэжлийн үнэмлэхтэй болгосон. | |
| 1.7.2 | Ахмад настанд чиглэсэн үйл ажиллагаа явуулдаг төрийн болон төрийн бус байгууллага, иргэдтэй хамтран хөгжил оролцоог дэмжин ажиллана. | ОНТ | Хамтран ажилласан байгууллагын тоо | 1 | 1 | Аймгийн ахмадын хороотой гэрээ байгуулан ахмад настнуудад мэдээ, мэдээлэл, сургалт, сурталчилгаа, хүндэтгэлийн болон нөлөөллийн арга хэмжээг тогтмол зохион байгуулж, тэдний нийгмийн оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр хамтран ажиллаж, орон нутгийн төсвөөс 150,1 сая төгрөгийн санхүүжилт олгон, үйл ажиллагааг байнга дэмжин ажиллалаа.<br>Аймгийн Ахмадын хорооноос зохион байгуулсан сумуудын ахмадын хорооны дарга нарын арга зүйн сургалт, зөвлөгөөнд Аймгийн Засаг дарга, Нийгмийн бодлогын хэлтсийн дарга нар оролцож, төр засгаас хэрэгжүүлж буй бодлого шийдвэрийн талаар мэдээлэл өглөө. Аймагт улсын төсвөөр Ахмадын сувилал баригдаж байгаа ба барилгын явцын ажил 50%-тай байна.<br>Сар шинийн баяраар аймгийн 90-аас дээш ахмад настан 67 хүнд аймгийн Засаг даргын гарын бэлгийг гардуулж өглөө. Ахмадуудад 7 хоногт 2 удаа биеийн тамирын заалыг үнэ төлбөргүй ашиглуулж, ахмадын биеийн тамир, спортын үйл ажиллагааг дэмжин, давхардсан тоогоор 2840 ахмад хамрагдлаа. Аймгийн төвд нийтийн тээврийн 2 автобусаар ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хүүхдүүд үнэ төлбөргүй үйлчлүүлж байна.<br>Улаанбаатар хотод зохион байгуулагдсан ахмадын зөвлөгөөнд аймгаас төр, төрийн бус байгууллагын төлөөлөл 5 хүн оролцож, санал бодлоо солилцлоо. "Ахмад настанд цогц үнэлгээ хийх" ажлыг ХХҮГ, Нэгдсэн эмнэлэг, сумдын өрхийн эрүүл мэндийн төвүүд хамтран зохион байгуулж, ахмад настны бие бялдар, танин мэдэхүй, сэтгэлзүй, үйл ажиллагааны чадвар, нийгмийн тулгамдсан асуудлыг тодорхойлох цогц үнэлгээнд 4337 ахмадыг хамрууллаа. ХХҮГ-ын дэргэдэх ахмадын сувилалд 460 ахмад настныг амрааж сувилуулан ахмадын туай хууль бусад мэдээ | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | мэдээллийг хүргэлээ. Үгийн бичгийг дэлгэрүүлэх цус ойртолтоос сэргийлэхэд ахмадудын үүрэг оролцоог нэмэгдүүлэх зорилгоор ХГБХХГ, ХХҮГ, ахмадын хороо хамтран 5 удаагийн сургалт, нөлөөллийн ажил зохион байгуулж, 82 ахмадыг хамрууллаа. "Ахмадаа хүндэлье" өдөрлөгт 92, аймгийн ахмадын спортын бага наадамд 5 төрлөөр 620, ахмад настны эрүүл идэвхтэй насжилтыг дэмжих цогц үйлчилгээнд 677 ахмад хамрагдлаа.Ахмад настнуудын дунд 7 хоног бүр нийтийн бүжиг зохион байгуулагдаж давхардсан тоогоор 1002 ахмад хамрагдлаа. "Говь-Алтай 80+" хөтөлбөрийн хүрээнд эрт илрүүлэг, явуулын эмнэлгийн үйлчилгээнд 458, нийт дээрх үйл ажиллагаанд давхардсан тоогоор 7646 ахмад настан хамрагдлаа."Хууль сурталчлах аян"-ы хүрээнд 24 аж ахуйн нэгж, байгууллагын 482 хүнд ахмад настны хуулийн талаар сургалт зохион байгуулж, зөвлөгөө мэдээлэл өглөө. Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг боловсрол, соёл урлаг, эрүүл мэнд, спортын чиглэлээр зохион байгуулж, 15 сум 1 тосгоны 58 ахмадыг хамруулж, ХЭДСангаас 62.6 сая төгрөг зарцууллаа. | |
| | 1.8. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн чиглэлээр | | | | | | |
| 1.8. 1 | Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах салбар зөвлөлийн үйл ажиллагааг идэвхжүүлж, төлөвлөгөө гарган баталж хэрэгжүүлэн ажиллана. | ОНТ | Хэрэгжилтийн хувь | 70 | 90 | Тус зөвлөл хуралдаж, 17 заалт бүхий ажлын төлөвлөгөөг баталж хэрэгжүүлэн ажиллаж байна. Үүнд: Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эх, асран хамгаалагчдын амьдралын чанарыг дээшлүүлэхэд төрийн болон төрийн бус байгууллагын уялдаа холбоог сайжруулах, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эх, асран хамгаалагч, тэдэнтэй ажилладаг мэргэжилтэн албан хаагчдын чадавхыг нэмэгдүүлэх, хүүхдүүдийг нарийн мэргэжлийн үзлэг оношлогоо, сэтгэл зүйн зөвлөгөө үйлчилгээнд хамруулах зорилгоор “Бэрхшээлийг боломж болгоё” нөлөөллийн үйл ажиллагааг 2025 оны 05 дугаар сарын 07-09-ний хооронд Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төвийн “Зөвлөх баг”-тай хамтран зохион байгууллаа. Энэ үеэр 05 дугаар сарын 07, 08-ны өдрүүдэд ЕБС, СӨБ-ын нийгмийн ажилтан, багш нар, сэтгэл зүйч, нэгдсэн эмнэлгийн эмч, салбар комиссын гишүүд, эцэг эхчүүдэд “Хөгжлийн бэрхшээлийн талаарх ерөнхий ойлголт”, “Тэгш хамралт, дэмжлэгийн баг ажиллах тухай”, “Ганцаарчилсан болон бүлгийн | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | төлөвлөгөө боловсруулах арга зүй", "Сэргээн засах эмчилгээ, хөдөлгөөн заслын үйлчилгээний ач холбогдол"-ын талаарх чадавхжуулах сургалтыг танхим болон бүлгийн хэлбэрээр зохион байгуулж 180 хүнийг хамрууллаа. 05 дугаар сарын 09-ний өдөр хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн нарийн мэргэжлийн үзлэг оношилгоонд давхардсан тоогоор 178 хүүхдийг хамруулж, сэтгэл зүйн зөвлөгөө үйлчилгээнд 40 хүүхэд, 21 эцэг эхчүүдийг хамрууллаа.Санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй 27 иргэнийг хамруулж ХЭДСангаас 160,000 мянган төгрөгийг 50 хувийн буцаан төлөх нөхцөлтэй, 36 сарын хугацаатай олголоо. Үүний үр дүнд 27 ажлын байр шинээр бий боллоо.<br>Эрх бүхий "Сонор эдүкейшин центр" ХХК-ийн дэргэдэх "Сонор" сургалтын төвтэй хамтран хөгжлийн бэрхшээлтэй болон хөгжлийн бэрхшээлтэй гэр бүлийн гишүүнээ асарч байгаа иргэдэд төсөл хөтөлбөр боловсруулах, өрхийн эдийн засгийн мэдлэг олгох болон зээлийн өмнөх, дараах сургалтыг зохион байгууллаа. Тус арга хэмжээнд 47 иргэнийг хамруулж ХЭДСангаас 2119,0 мянган төгрөг зарцууллаа. Аймгийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн холбооноос ирүүлсэн хүсэлтэд үндэслэн Улаанбаатар хотын эрх бүхий "Дардан ирээдүй холбоо" НҮТББ-тай хамтран хөгжлийн бэрхшээлтэй 17 иргэнийг үсчиний мэргэжил олгох сургалтад хамруулж ХЭДСангаас сургалтын төлбөрт 3.4 сая төгрөгийг зарцууллаа. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн дунд зохион байгуулагддаг "Монгол Абилимп 2025" ур чадварын уралдаан тэмцээнд оролцсон иргэдийн төлөөлөлд 1.4 сая төгрөг, Архангай аймагт зохион байгуулагдсан үндэсний "Пара-спорт2025" улсын аварга шалгаруулах 5 төрөлт тэмцээнд оролцогчдод 2.0 сая төгрөгийн дэмжлэгийг тус тус үзүүллээ. | |
| 1.8.2 | Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн | ОНТ | Хэрэгжилтийн хувь | 90 | 90 | Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комисс нь 16 удаа хуралдаж, 175 хүүхдийн хөгжлийн бэрхшээл болон байнгын асаргааны асуудлыг хэлэлцсэн байна. Үүнээс: шинээр хөгжлийн бэрхшээлтэй болохыг тогтоолгосон | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хамгааллын салбар комиссын дүрмийн 1.10, 2.5, 2.7, 3.3.7, 3.3.8, 6.1-ийн хэрэгжилтийг хангаж ажиллаж, үйл ажилагааны зардлыг орон нутгийн төсөвт тусгах, албан байраар болон гишүүдийн ажиллах нөхцөлийг хангаж, тулгамдсан асуудлыг шийдвэрлэх, хүүхдийн хөгжлийн хоцрогдол, бэрхшээлээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг тогтмол зохион байгуулах зэрэг шаардлагатай дэмжлэг, туслалцааг үзүүлнэ. | | | | | 11 хүүхэд, шинээр байнгын асаргаанд байх шаардлагатайг тогтоолгосон 27 хүүхэд, байнгын асаргааны хугацааг сунгуулсан 100 хүүхэд, буцсан 14 хүүхэд байна. Баян-Өлгий аймагт зохион байгуулагдсан "Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комисс"-ын гишүүдийг чадавхжулах сургалтад 5 хүнийг хамруулж, аймгийн Засаг даргын Тамгын газраас 2.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүллээ. | |
| 1.8.3 | Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ээлтэй орчин бүрдүүлэх, тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулна. | УТ,ОНТ | Ээлтэй орчин бүрдүүлсэн байгууллагын тоо Үзлэгт хамрагдсан иргэдийн хувь | - | 5 | Аймгийн ахмадын хороотой гэрээ байгуулан ахмад настнуудад мэдээ, мэдээлэл, сургалт, сурталчилгаа, хүндэтгэлийн болон нөлөөллийн арга хэмжээг тогтмол зохион байгуулж, тэдний нийгмийн оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр хамтран ажиллаж, орон нутгийн төсвөөс 150,0 сая төгрөгийн санхүүжилт олгон, үйл ажиллагааг байнга дэмжин ажиллалаа. Сар шинийн баяраар аймгийн 90-аас дээш ахмад настан 67 хүнд аймгийн Засаг даргын гарын бэлгийг гардуулж өглөө. Ахмадуудад 7 хоногт 2 удаа биеийн тамирын заалыг үнэ төлбөргүй ашиглуулж байна. Аймгийн төвд нийтийн тээврийн 2 автобусаар ахмад настан, хөгжлийн | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | бэрхшээлтэй иргэн, хүүхдүүд үнэ төлбөргүй үйлчлүүлж байна.<br>“Ахмад настанд цогц үнэлгээ хийх” ажлыг ХХҮГ, Нэгдсэн эмнэлэг, сумдын өрхийн эрүүл мэндийн төвүүд хамтран зохион байгуулж, ахмад настны бие бялдар, танин мэдэхүй, сэтгэлзүй, үйл ажиллагааны чадвар, нийгмийн тулгамдсан асуудлыг тодорхойлох цогц үнэлгээнд 4337 ахмадыг хамрууллаа. ХХҮГ-ын дэргэдэх ахмадын сувилалд 460 ахмад настныг амрааж сувилуулан ахмадын туай хууль бусад мэдээ мэдээллийг хүргэлээ.<br>“Тунгалаг аялгуу” ХХК-аас 12 ахмад настан, 10 хөгжлийн бэрхшээлтэй иргэнд сонсголын аппарат тохируулж, нийгмийн халамжийн сангаас 19, 6 сая төгрөгийг зарцууллаа. Аймгийн хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан стандандартад нийцсэн налуу шаттай 34, тусгайлан тоноглосон ариун цэврийн өрөөтэй 6 байгууллага байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэн үйлчлүүлэхэд хүртээмжтэй, саадгүй орж гарах нөхцлийг сайжруулах чиглэлээр аймгийн хэмжээнд үйл ажиллагаа эрхэлж байгаа төрийн байгууллагуудад албан бичиг хүргүүлснээр шинээр баригдсан 19 байгууллага гадна талынхаа налуу замыг стандарт шаардлагын дагуу хийж гүйцэтгэлээ. Аймгийн хэмжээний 2621 хөгжлийн бэрхшээлтэй иргэдээс урьдчилан сэргийлэх үзлэгт 665 хүн хамруулж, гэрийн эргэлтийг 437 хүнд хийснээр нийт 1102 буюу 42.0 хувь эрүүл мэндийн тусламж үзүүлсэн байна. "Говь-Алтай 80+" хөтөлбөрийн хүрээнд эрт илрүүлэг, явуулын эмнэлгийн үйлчилгээнд 458, нийт дээрх үйл ажиллагаанд давхардсан тоогоор 7646 ахмад настан хамрагдлаа."Хууль сурталчлах аян"-ы хүрээнд 24 аж ахуйн нэгж, байгууллагын 482 хүнд ахмад настны хуулийн талаар сургалт зохион байгуулж, зөвлөгөө мэдээлэл өглөө. | |
| 1.8.4 | Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эх, асран хамгаалагчийн хөгжлийн бэрхшээлийн | УТ,ОНТ | Хамтран ажилласан байгууллагын тоо | 1 | 1 | 2025 оны 05 дугаар сарын 07, 08-ны өдрүүдэд ЕБС, СӨБ-ын нийгмийн ажилтан, багш нар, сэтгэл зүйч, нэгдсэн эмнэлгийн эмч, салбар комиссын гишүүд, эцэг эхчүүдэд “Хөгжлийн бэрхшээлийн талаарх ерөнхий ойлголт”, “Тэгш хамралт, дэмжлэгийн баг ажиллах тухай”, “Ганцаарчилсан болон бүлгийн төлөвлөгөө боловсруулах арга зүй”, “Сэргээн засах эмчилгээ, | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | талаарх мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх, хүүхдээ нийгмийн идэвхтэй гишүүн болгоход чиглэсэн чадавхжуулах хөтөлбөрийг энэ чиглэлээр мэргэшсэн төрийн бус байгууллагатай хамтран хэрэгжүүлнэ. | | | | | хөдөлгөөн заслын үйлчилгээний ач холбогдол"-ын талаарх чадавхжуулах сургалтыг танхим болон бүлгийн хэлбэрээр зохион байгуулж 180 хүнийг хамрууллаа. 2025 оны 04 дүгээр сарын 26-ны өдөр "Төрөлх-Алтай" ТББ-аас төлөөлөл ирж, Есөнбулаг сумын-7, Баян-Уул сумын-1, Цээл сумын-1, Эрдэнэ сумын-1 нийт 10 хүүхдэд тэргэнцэр гардуулан өглөө.<br><br>Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн гэрийн үзлэгийг зохион байгуулж, давхардсан тоогоор 180 хүүхэд хамрагдаж, эцэг эхэд нь зөвлөгөө мэдээлэл өглөө.<br><br>Есөнбулаг сумын сургууль, цэцэрлэгийн тусгай хэрэгцээт хүүхдийн "Хүүхэд хөгжлийн төв"-ийн үйл ажиллагаатай танилцан хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комисс,сургууль,цэцэрлэгийн багш ажилчдад мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллалаа.Тусгай хэрэгцээт хүүхдүүдтэй ажилладаг 7 багшид хөгжлийн бэрхшээлийн талаарх ойлголт мэдээллийг хүргэн ажиллалаа. Хөхморьт, Баян-уул, Бигэр, Цогт сумдын тусгай хэрэгцээт хүүхдийн "Хүүхэд хөгжлийн төв"-ийн багш ажилтан нарт цахим сургалт зохион байгуулан хөгжлийн бэрхшээлийн талаарх ойлголт мэдээлэл,нийгмийн халамжийн сангаас олгодож буй тэтгэвэр,тэтгэмж,тусламж,хөнгөлөлтийн талаарх мэдээллийг тус тус хүргэлээ. УИХ-ын гишүүн Баясгалан хөгжлийн бэрхшээлтэй иргэдтэй уулзалт хийж, төр засгаас баримталж буй бодлогын талаар мэдээлэл өгч, 200 гаруй хүн хамрагдлаа. Бусийн хэмжээнд болон аймагт зохион байгуулсан бүх сургалтад зардал шийдэж оролцуулж байна. | |
| 1.8.5 | Нутаг дэвсгэрийн хэмжээнд хэрэгжүүлж байгаа бодлого, хөтөлбөр, төлөвлөгөөг Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн | УТ,ОНТ | Хэрэгжилтийн хувь | - | 90 | "Хөдөлмөрөөр өөрчлөлтийг эхлүүлцгээе" өдөрлөгийг Есөнбулаг, Баян-уул, Бигэр, Чандмань, Эрдэнэ, Баянтоорой, Цогт, Цээл, Алтай, Төгрөг сумдад зохион байгууллаа. Өдөрлөгийн үеэр "Нийгмийн халамжийн тухай" багц хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан бусад эрх зүйн актуудын хэрэгжилтийн хүрээнд нийгмийн халамжийн сангаас олгодог тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлт тусламжийн талаарх мэдээллийг | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | тухай конвенцод нийцэж байгаа эсэхийг судлан Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн хорооноос ирүүлсэн зөвлөмжийг хэрэгжүүлэх, олон нийтэд сурталчлан таниулах ажлыг зохион байгуулна. | | | | | иргэдэд хүргэж, нийгмийн халамжийн үйл ажиллагаатай холбоотой санал хүсэлтийг шийдвэрлэж, арга зүйн зөвлөгөө өгч ажиллалаа. Мөн хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үзүүлж буй үйлчилгээ, хөдөлмөр эрхлэлтийн талаарх мэдээллийг хүргэлээ.<br>2025 оны 05 дугаар сарын 07, 08-ны өдрүүдэд ЕБС, СӨБ-ын нийгмийн ажилтан, багш нар, сэтгэл зүйч, нэгдсэн эмнэлгийн эмч, салбар комиссын гишүүд, эцэг эхчүүдэд “Хөгжлийн бэрхшээлийн талаарх ерөнхий ойлголт”, “Тэгш хамралт, дэмжлэгийн баг ажиллах тухай”, “Ганцаарчилсан болон бүлгийн төлөвлөгөө боловсруулах арга зүй”, “Сэргээн засах эмчилгээ, хөдөлгөөн заслын үйлчилгээний ач холбогдол”-ын талаарх чадавхжуулах сургалтыг танхим болон бүлгийн хэлбэрээр зохион байгуулж 180 хүнийг хамрууллаа. “Хан-Алтай ресурс” ХХК-ын 35,0 сая төгрөгийн санхүүжилтээр хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 2 өрөөг засварлаж, аймгийн ажлын хэсэг засварын ажилтай үзэж танилцан хүлээн авлаа. Тус өрөөнүүдийг хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн салбар зөвлөлд хүлээлгэн өгч, үйл ажиллагаагаа явуулан мэдээ мэдээллийг тогтмол хүргэж байна. | |
| | ХОЁР. Хуулиар тусгайлан олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээ | | | | | | |
| 2.1.1 | Жендэрийн эрх тэгш байдлыг хангах салбар дундын стратегийг хэрэгжүүлж ажиллана. | УТ, ОНТ | Хэрэгжилтийн хувь | 87 | 90 | Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд заасан 9 төрлийн тайлан мэдээ мэдээллийг сум, байгууллагаас авч нэгтгэн Жендэрийн үндэсний хороонд хугацаанд нь хүргүүллээ.<br>Жендэрийн эрх тэгш байдлыг хангах салбар дундын стратегийг хэрэгжүүлэх 29 заалт бүхий төлөвлөгөөг жендэрийн салбар хороогоор хэлэлцүүлэн аймгийн Засаг даргаар батлуулж, сум байгууллагуудад хүргүүллээ.<br>Япон Улсын Засгийн газрын “Өвсний үндэс” буцалтгүй тусламжаар баригдсан “Түр хамгаалах байр”-ыг 2024 оны 12 дугаар сарын 26-ны өдөр хүлээн авч, аймгийн Засаг даргын 2025 оны А/44 тоот захирамжаар бүтэц орон тоог 5-аар батлан, гэр бүлийн хүчирхийллийн хохирогчид үзүүлэх үйлчилгээний зардлыг орон нутгийн төсөвт тусган, үйл ажиллагааг хэвийн явуулж байна. Энэ оны эхний 11 сарын байдлаар хүүхэд 25, насанд хүрэгч 7, нийт 32 хүнийг аюулгүй байдлын хамгаалалтад авч, үйлчилгээ үзүүлэн, хохирогчийг гэр | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | бүлд нь эргэн нэгтгэж ажиллалаа. Түр хамгаалах байранд орон нутгийн төсвөөс 119.0 сая төгрөг шийдвэрлэсэн. "Гэр бүлд зөвлөгөө өгөх төв"-ийн нийгэм, сэтгэл зүйн зөвлөгөө үйлчилгээнд хүүхэд 91, насанд хүрэгч 62 нийт 153 хүнийг хамрууллаа. Хүчирхийлэл үйлдэгчийн зан үйлд нөлөөлөх 26 удаагийн албадан сургалтад 100 иргэнийг хамрууллаа. Аймгийн хэмжээнд ажиллаж буй 30 хамтарсан баг гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 68 удаагийн сургалт, нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулж, 3470 хүнийг хамрууллаа. "Гэр бүлд зөвлөгөө өгөх төв"-өөр дамжуулан олон нийтэд гэр бүлийн боловсрол олгох сургалт, нөлөөллийн арга хэмжээнд 2500 гэр бүл, 9792 иргэнийг хамруулсан нь нийт өрхийн 15.2%-ийг эзэлж байна. Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх 16 хоногийн аянд төр, төрийн бус, аж ахуйн нэгж, байгууллага, иргэд олон нийт нэгдэж, гэр бүлийн болон охид эмэгтэйчүүдийг эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх талаар мэдээ мэдээлэл өгч, сургалт, сурталчилгаа, нөлөөллийн ажил зохион байгууллаа. Харилцан хүндэтгэе" аян зохион байгуулж, аймаг, сумын байгууллагууд фэйж хуудасны нүүр зураг болон ковер зургийг уриа бүхий зургуудаар сольж, нийгмийн сүлжээнд аяны үйл ажиллагааг сурталчилж, шторк, мэдээ мэдээллийг иргэд, албан хаагчдад хүргэж, охид, эмэгтэйчүүдийн эсрэг үйлдэгдэж буй жендэрт суурилсан хүчирхийллийг эсэргүүцэн хүчирхийллийн эсрэг хамтдаа тэмцэхийг уриаллаа. 2025 онд салбар зөвлөлөөс аймгийн Уламжлалт анагаах ухааны нэгдсэн эмнэлгийн эрүүл мэндийн ажилтнууд, Алтай чуулга, Алтай орон сууцны корпораци, татварын газрын албан хаагчдад "Жендэрийн ерөнхий ойлголт", "Жендэрийн эрх тэгш байдлыг хангах бодлого төлөвлөлт" сэдвээр сургалт зохион байгуулж эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн эрх тэгш эн тэнцүү байдлыг хангах, үүнээс үүдэлтэй ялгаварлан гадуурхалт, хүчирхийллээс ангид байх, хөдөлмөрийн харилцаанд тулгарч буй бэрхшээл, ялгаатай байдлаас үүсэх эрэлт, хэрэгцээ зэрэг өргөн хүрээнд мэдээлэл хийн, харилцан ярилцлаа. Аймгийн ЗДТГ болон сумдын жендэрийн мэдрэмжтэй ажлын байрын бодлогын хэрэгжилтийг тайлагналаа. "Жендэрийн тэгш байдал ба | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | уур амьсгалын өөрчлөлт" хэлэлцүүлэг зохион байгуулагдаж, 30 гаруй хүн хамрагдлаа. "Дархан бэр", "Уран бэр" энгэрийн тэмдэг олгох, өргөмжлөх зэрэг арга хэмжээ нь хүний эрхийг зөрчиж байгаа талаарх жендэрийн үндэсний шинжээчдийн бүлгийн дүгнэлтийг аймаг, сумдын пейж хуудас, байгууллагуудын пейж хуудас, хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд сурталчилж, жендэрийн цахим тестэд 890 гаруй хүн хамрагдлаа. | |
| 2.1.2 | Аймгийн Засаг даргын салбарын сайдуудтай байгуулсан гэрээний хэрэгжилтийг хугацаанд нь тайлагнаж, сумын Засаг дарга нартай байгуулсан гэрээний нийгмийн салбарын зорилтуудын хэрэгжилтэд хяналт тавина. | УТ, ОНТ | Хэрэгжилтийн хувь | 90 | 90 | Аймгийн Засаг даргын салбарын сайдуудтай байгуулсан гэрээний хэрэгжилтийн эхний хагас жилийн болон жилийн эцсийн биелэлтийг ХШҮХэлтсээр хянуулж, хугацаанд нь хүргүүллээ. | 100 |
| | **ГУРАВ. Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээ** | | | | | | |
| 3.1 Төрийн албаны тухай хууль болон бусад холбогдох хууль журмын хэрэгжилтийг хангах | | | | | | | |
| 3.1.1 | Төрийн албан хаагчийн ёс зүйг баримтлан ажиллаж, удирдлагаас өгсөн үүрэг, даалгавар, хариутай бичгийг хугацаанд нь шийдвэрлүүлнэ. | - | Хугацаанд нь биелүүлсэн ажлын тоо | Хугацаанд нь | Хугацаанд нь | Удирдлагаас өгсөн болон мэргэжилтнүүдийн санаачилгаар 82 захирамж гаргаж, хэрэгжүүлж ажиллалаа. Яам, бусад байгууллагаас ирсэн 160 бичгийг хугацаанд нь шийдвэрлэж хүргүүллээ. Иргэдэд төрийн үйлчилгээг түргэн шуурхай хүргэж, хэлтэст ирсэн 20 өргөдөл, гомдлыг хугацаанд нь шийдвэрлэж, албан бичгээр хариуг өглөө. | 100 |
| 3.1.2 | Хэлтсийн 2024 оны хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу хадгаламжийн нэгж бүрдүүлж, байгууллагын | - | Хадгаламжийн нэгжийн тоо | 11 | 11 | Боловсрол, соёл, эрүүл мэнд, хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгаалал, жендэр, төрийн бус байгууллагын чиглэлээр 11 архивын нэгж бүрдүүлж, хүлээлгэн өглөө. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | архивт хүлээлгэж өгнө. | | | | | | |
| 3.1.3 | Байгууллага дээр зохион байгуулагдах сарын ажлыг хуваарийн дагуу зохион байгуулна. | - | Төлөвлөгөө | 1 | 1 | Тус хэлтэс нь 06 дугаар сарыг хариуцан ажиллаж, 8 арга хэмжээ зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна. Үүнд: 2025.06.05-ны өдөр байгууллагын албан хаагчдад гэр бүлийн боловсрол олгох сургалтыг Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын газрын мэргэжилтэнтэй хамтран, Цусны донор гэж хэн бэ? сургалтыг нэгдсэн эмнэлэг, Улаан загалмайн хороотой хамтран тус тус зохион байгуулж, 20 гаруй албан хаагчид хамрагдлаа. 2025.06.06-нд цусны донорын дэлхийн өдрийг угтаж байгууллагын албан хаагчид цусаа бэлэглэх арга хэмжээний бэлтгэл ажлын хангаж, заал уртасгагч, ус буцалгагч бэлдэж, 2 албан хаагч цусаа бэлэглэсэн. 2025.06.19-ны өдөр байгууллагын албан хаагчдын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, хөдөлгөөний хомсдолоос урьдчилан сэргийлэх зорилгоор буухиа тэмцээнийг зохион байгуулж, эхний 3 байрыг шагнаж урамшууллаа. | 100 |
| 3.1.4 | Албан тушаалтны 2024 оны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг хуулийн хугацаанд гаргаж, тайлагнана. | - | Мэдүүлэг гаргах албан хаагчийн тоо | 2 | 2 | Албан тушаалтны 2024 оны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг хэлтсийн дарга болон ахлах мэргэжилтэн 2025 оны 02 дугаар сарын 15-наас өмнө гаргаж программд оруулан баталгаажууллаа. | 100 |
| | ДӨРӨВ. Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилт, арга хэмжээ | | | | | | |
| 4.1. | Харьяа агентлагуудын үйл ажиллагаатай танилцах, зөвлөн туслах, мэргэжилтнүүдийг сургаж дадлагажуулах ажлыг тогтмолжуулж ажиллана. | - | Зөвлөн тусалсан байгууллагын тоо | 7 | 7 | Хэлтсийн дарга болон мэргэжилтнүүд салбарын байгууллагуудын үйл ажиллагаатай танилцаж, тайлан мэдээ гаргах болон бусад асуудлаар санал солилцож, заавар, зөвлөгөө өглөө.<br>2025 оны 02-р сард төрийн байгууллагуудын үйл ажиллагаа, төрийн албаны тухай хууль холбогдох бусад хуулиар хүлээсэн чиг үүргээ биелүүлж буй байдал, аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт, аймгийн Засаг дарга сайдуудтай байгуулсан гэрээний хэрэгжилт, ажлын байрны тодорхойлолт, цаг ашиглалт зэргийг | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | үзэж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх зорилгоор аймгийн ЗДТГ-ын баталсан удирдамжийн дагуу ажлын хэсэгт орж ажиллан Нийгмийн даатгалын газар, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, Эрүүл мэндийн даатгалын хэлтэс гэсэн байгууллагуудын үйл ажиллагаатай танилцаж, заавар, зөвлөгөө өглөө. 2025 оны 09-р сард дарга мэргэжилтнүүд архив, албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэгийн ажлын хэсэгт орж ажиллан 21 байгууллагыг шалгаж, заавар зөвлөгөө өгч, тайлан мэдээг нэгтгэн архивын хэлтэст хүлээлгэн өглөө. | |
| 4.2 | Сумын ЗДТГ-н үйл ажиллагаанд зөвлөн туслах, сургалт зохион байгуулах | - | Зөвлөн тусалсан сумын тоо | 3 | 3 | Сумдын удирдлагуудын сургалт, уулзалтад хэлтсийн дарга оролцож, нийгмийн салбарын талаар хэрэгжүүлж буй арга хэмжээний талаар мэдээлэл өглөө. Мөн хэлтсийн дарга бүх сумдад Засаг даргатай хамт ажиллаж, иргэдийн санал хүсэлтийг хүлээн авч тулгамдсан асуудлыг шийдвэрлэж ажиллалаа. | 100 |
| 4.3 | Аймгийн Засаг даргаас сум, Агентлагын удирдлагуудтай байгуулсан гэрээнд тусгасан заалтуудыг хэрэгжүүлэх ажилд хяналт тавьж, чиглэл зөвлөмж өгч ажиллах | - | Зөвлөмж, чиглэлийн тоо | - | 4 | Аймгийн Засаг даргаас сум, агентлагын удирдлагуудтай байгуулсан гэрээнд тусгасан заалтуудыг хэрэгжүүлэх ажилд хяналт тавин ажиллаж, заавар зөвлөгөө өглөө. | 100 |

ХЯНАСАН:
НИЙГМИЙН БОДЛОГЫН ХЭЛТСИЙН ДАРГА Ж.АМГАЛАНБААТАР

БИЕЛЭЛТ НЭГТГЭСЭН:
НИЙГМИЙН БОДЛОГЫН ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН Л.АРИУНТУЯА